

А. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

Улсын бүртгэлийн
Дугаар.....

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

УЛААНБААТАР ХОТЫН УНДНЫ УСНЫ ГИДРОХИМИЙН БОЛОН ОРГАНИК БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУДАЛГАА

Суурь судалгааны төсөлт ажлын тайлан
2019-2021 он

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

Улсын бүртгэлийн
Дугаар.....

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар:

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

**УЛААНБААТАР ХОТЫН УНДНЫ УСНЫ ГИДРОХИМИЙН
БОЛОН ОРГАНИК БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУДАЛГАА**
Суурь судалгааны төсөлт ажлын тайлан
2019-2021 он

Төсөлт ажлын удирдагч:
Санхүүжүүлэгч байгууллага:
Захиалагч байгууллага:
Тайлан өмчлөгч:

Б. Амарсанаа – доктор (Ph.D)
Шинжлэх ухаан технологийн сан
Боловсрол шинжлэх ухааны яам
Хими, химийн технологийн хүрээлэн
*ШУА-ийн IV байр, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө,
13330 Улаанбаатар
Утас (+976-11)-453133, 453334
Факс: (+976-11)-453133*

Реферат

Төсөлт ажлын зорилго: Улаанбаатар хотын ундны ус түгээгүүрийн Б (Үйлдвэрийн эх үүсвэр), В (Мах комбинатын эх үүсвэр) станцын гидрохимийн горимын судалгаа, гэр хорооллын гүний худгийн ус болон гадаргын усны химийн найрлагын шинж чанар түүнд агуулагдах органик бүрэлдэхүүн, хүнд металлын агуулгыг тодорхойлж, өөрийн болон олон улсын стандарттай харьцуулан дүгнэлт өгөх зорилготой.

Зорилт:

- ❖ Улаанбаатар хотын ус түгээгүүрийн Б, В станцын ус болон түгээлтийн дамжлагаас улирал тутам дээж авч ундны усны чанарын үзүүлэлтүүд болон органик бүрэлдэхүүний судалгааг явуулж өөрийн орны болон олон улсын стандарттай харьцуулан дүгнэлт өгөх
- ❖ Улаанбаатар хотын сонгогдсон гэр хорооллын ундны усны зориулалтаар хэрэглэж буй гүний худгийн усны гидрохими, эрүүл ахуйн үзүүлэлт болон органик бүрэлдэхүүний судалгааг нарийвчлан явуулж үндэсний болон олон улсын стандарттай харьцуулан дүгнэлт өгөх
- ❖ Улаанбаатар хотын гадаргын усны физик-химийн найрлага, хүнд метал, бохирдлыг тогтоох судалгааг явуулж олон улсын стандарттай харьцуулан үнэлгээ өгөх

Судалгааны арга зүй: Тайлангийн хугацаанд судалгаанд хамрагдсан ус хангамжийн эх үүсвэрийн гүний худаг, “Б, В” станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны ус, гэр хорооллын гүний худаг, гадаргын усны ерөнхий физик-химийн үзүүлэлт, бичил амь судлалын шинжилгээг ХХТХ-н Экологийн химийн лабораторид, микроэлементийн шинжилгээг SGS лабораторид, цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг МУИС-н Цөмийн судалгааны төвд тус тус тодорхойлсон болно.

Үйлдвэрийн эх үүсвэрийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа:

Үйлдвэрийн районы буюу Б станцын эх үүсвэрийн гүний худгуудын ус нь саармаг орчинтой, зөөлнөөс хатуу, нэн цэнгэгээс цэнгэгдүү гидрокарбонат, сульфат-кальци, сульфат-кальци, магни, гидрокарбонат-кальци, магнийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. усны ангилалд хамаарагдаж байна. 2019-2022 оны ундны усны химийн найрлагыг тодорхойлсон үр дүнгээс харахад эх үүсвэрийн 16 гүний худгуудаас 4 худаг нийт хатуулаг, кальцийн ион, 2 худаг нитрат ион, 3 худаг молибдены агуулгаараа мөн 6 худгийн усны фторын ионы агуулга ундны усны стандартад тусгагдсан доод утгад хүрээгүй, 8 худгийн усны фторын ион Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тусгагдсан дээд утгаас давсан байгаа нь MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байна. Түүнчлэн 2020 онд 2-р худгийн усанд нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн нян, *Escherichia coli*, халуун тэсвэртэй бактери илэрсэн байсан бол 2022 оны IV улиралд хийсэн шинжилгээгээр тус худаг стандартын шаардлага хангаж байгаа нь тухайн худагт ариутгал халдваргүйжүүлэлт хийснийг илтгэж байна. Мөн 2020 оны шинжилгээгээр 1 худаг, 2021 онд 4 худаг, 2022 онд 5 худгийн ус бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байна. Энэ нь сорьц цуглуулж

байх үед худаг доторх усны дээж авах крант ажиллаагүй удсан, ус удаан гоожуулах боломжгүй зэргээс хамаарсан байх магадлалтай.

Үйлдвэрийн эх үүсвэрийн Б-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны усны гидрохимийн судалгаа: Б-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдэд хүрч буй ус нь саармаг орчинтой, зөөлнөөс хатуувтар, буюу нэн цэнгэгээс цэнгэг усны ангилалд хамаарагдаж байна. 2020-2021 онд Б-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны усанд хийсэн химийн шинжилгээний дүнгээс харахад станцын усанд үлдэгдэл хлор илэрч байгаа хэдий ч эхний болон эцсийн хэрэглэгчдийн усанд илрэхгүй байна. Энэ нь тухайн өдрийн халдваргүйжүүлэлтийн хлорын тун хэмжээнээс хамаардаг. Б-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны усны жил, улирлын химийн шинжилгээний үр дүнгээс харахад ионуудын тоон утгын хувьд бага зэрэг зөрүүтэй байгаа хэдий ч үндсэн бүтэц найрлага өөрчлөлтгүй байна. Үндсэн катион, анионуудын тоон утга бага зэрэг зөрүүтэй байгаа нь тухайн өдөр ажиллаж байгаа гүний худгийн усны найрлагатай шууд хамааралтай байгааг тодорхойлов. Харин Б-станцын халдваргүйжүүлэлт хийсний дараах ус бичил амь судлалын үзүүлэлтээрээ MNS стандарт шаардлага хангаж байхад хэрэглэгчдийн ундны уснаас 2020-2022 оны (II, III, IV) улиралд нийт нянгийн тоо стандартын ЗДА-с хэтэрсэн нь MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байгааг тодорхойлов. Энэ нь дээж авах үед хэрэглэгчдийн ашиглаж буй крантны ариун цэврээс бас их шалтгаалж байсан.

Мах комбинатын эх үүсвэрийн гүний худгуудын гидрохимийн судалгаа: Судалгаанд хамрагдсан Мах комбинатын эх үүсвэрийн 11 гүний худгийн ус саармаг орчинтой, зөөлөвтрөөс хатуувтар, цэнгэгээс цэнгэгдүү, гидрокарбонат-кальци, сульфат-кальци, гидрокарбонат, сульфат-кальцийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. 2020-2021 онд хийсэн химийн шинжилгээний дүнгээс харахад 1 худаг кальцийн ион, 5 худаг цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна. Эх үүсвэрийн гүний худгуудын усны радоны агуулга харьцангуй өндөр байгаа нь тухайн худгууд дулааны 2-р цахилгаан станцын хажууд байрладаг мөн усны урсцын хэмжээнээс хамаарч байх магадлалтай. Мөн бичил амь судлалын шинжилгээгээр 2022 оны I, IV улиралд 1 худаг, 2021 оны III улиралд 1 худаг, 2022 оны IV улиралд 2 худгийн усанд нийт нянгийн тоо стандарт хэмжээнээс хэтэрсэн байгаа нь MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байгааг тодорхойлов.

Мах комбинатын эх үүсвэрийн В-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны усны гидрохимийн судалгаа: В-станц халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ус нь саармаг орчинтой, зөөлнөөс хатуувтар, нэн цэнгэгээс цэнгэгдүү усны ангилалд хамаарагдаж байна. 2020-2022 оны химийн шинжилгээний дүнгээс харахад В-станцын халдваргүйжүүлэлтийн дараах усанд үлдэгдэл хлор стандарт хэмжээнд илэрч байсан бол эхний хэрэглэгч болох (20-р хорооны байрны) усанд бага агуулгатай байна. В-станц болон хэрэглэгчдийн усны фторын ионы агуулга Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тусгагдсан доод утгад хүрэхгүй байгаа нь мөн станцын усанд радон илэрч байгаа нь

MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байна. Станцын усанд радон илэрч байгаа нь тухайн өдөр ажиллаж байгаа гүний худгийн усны найрлагатай шууд хамааралтай байгааг тодорхойлов. В-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны усны жил, улирлын химийн шинжилгээний үр дүнгээс харахад ионуудын тоон утгын хувьд бага зэрэг зөрүүтэй байгаа хэдий ч үндсэн бүтэц найрлага өөрчлөлтгүй байна. Мөн В-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн усны бичил амь судлалын шинжилгээгээр Гал унтраах 18-р анги, 20-р хорооны байрны нийт нянгийн тоо MNS 0900:2018 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн байна.

Б, В станцын органик бүрэлдэхүүний судалгаа: Улаанбаатар хотын ус хангамжийн Б, В станцын эх үүсвэрийн худгууд, халдваргүйжүүлэлтийн дараах усанд органик бүрэлдэхүүнийг тодорхойлж Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт болон бусад улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарттай харьцуулан дүгнэлт гаргав. Хлор ашиглан халдваргүйжүүлэлт явуулахад усанд үүсэж болох органик нэгдлүүд буюу хлорформ, бромдихлорметан, дибромхлорметан, бромформ Б, В станцын усанд илэрч байгаа хэдий ч эдгээрийн нийлбэр тригалогентметаны хэмжээ нь MNS 0900:2018 болон бусад улс орны мөрддөг ундны усны стандартаас 10-25 дахин бага байна. Мөн үйлдвэрийн гаралтай органик бүрэлдэхүүний агуулгыг давтамжит хугацаагаар мониторинг хийж судлах нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Харин Б, В станцын эх үүсвэрийн зарим худгуудад толуол, стирен болон ксилолын уламжлалууд илэрсэн ч стандартад заасан хэмжээнээс маш бага байна. Үүний дотроос толуол болоод ксилолын уламжлалууд нэлээдгүй илэрсэн нь түлшний гаралтай нэгдлүүдийн өвөрмөц хувирал зүй явагдсан нь тогтцын хувьд болон шилжилтийн улмаас сонирхолтой үр дүн гарсан нь органик бүрэлдэхүүний судалгааг цаашид ангилан үргэлжлүүлэх шаардлага байна.

Гэр хорооллын иргэдийн үнд, ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудын усны чанарын судалгаа:

Баянзүрх дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа: Энэхүү судалгаагаар Баянзүрх дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгийн усанд нарийвчилсан судалгааг явуулсны үндсэн дээр усны чанарыг үнэлэх мөн эрдэсжилтээс хамааруулан ус чулуулгийн харилцан үйлчлэлийг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн. Баянзүрх дүүргийн 7 хороонд байрлах унд ахуйн зориулалтаар ашигладаг 55 гүний худгуудын ус нь саармагаас сул шүлтлэг орчинтой, зөөлнөөс зөөлөвтөр устай 46 худаг, хатуувтраас хатуу устай 9 худаг байгаа ба 53 гүний худаг нь гидрокарбонат-кальци, магни, бусад нь гидрокарбонат-магни болон сульфат-натрийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. Баянзүрх дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй нийт 55 гүний худгийн ус судалгаанд хамрагдсанаас 25 худгийн ус нь зарим анион, катион болон бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гаргасан улс орнуудын мөрддөг ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байна. Харин 30 гүний худгийн ус нь бүх үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөж буй MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна. Ус, чулуулгийн харилцан үйлчлэлийг Гиббсийн диаграмм ашиглан тодорхойлоход гүний худгуудын ус нь чулуулаг давамгайлсан мужид оршиж байгаа нь

худгийн усны найрлага тухайн орчны геологийн тогтоц болон чулуулгаас хамаарч байгаа бөгөөд ус, чулуулгийн харилцан үйлчлэлд орж байна.

Баянгол дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа: Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20, 22, 23-р хороонд байрлах унд, ахуйн зориулалтаар ашигладаг 18 гүний худгуудын ус саармаг орчинтой, зөөлнөөс маш хатуу, нэн цэнгэгээс давсархаг, 22, 23-р хорооны 3 худгийн ус гидрокарбонат-кальци, магни, бусад худгуудын ус нь гидрокарбонат, сульфат-кальци, магнийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. Судалгаанд хамрагдсан нийт гүний худгуудаас 23-р хороонд байрлах 1 худгийн ус цахилгаан дамжуулах чанар, 23-р хорооны 2 худаг нийт хатуулаг, Mg^{2+} , 20, 22, 23-р хорооны 3 худаг Ca^{2+} , 20, 22-р хорооны 5 худгийн ус NO_3^- ионы агуулгаараа Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байгааг тогтоолоо. Мөн тус дүүргийн гүний худгуудын усны бичил амь судлалын шинжилгээгээр 4 худгийн усны нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн, 14 худгийн усанд гэдэсний бүлгийн нян илэрсэн нь MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байгааг тодорхойлов. Эдгээр худгуудын усыг унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй тул эрүүл ахуйн бүс тогтоож, ариутгал халдваргүйжүүлэлт хийсний дараа хэрэглэх шаардлагатай.

Сүхбаатар дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа: Төсөлт ажлын хүрээнд нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгийн усанд судалгаа хийж, усны чанарыг үнэлэн дүгнэлт өгөх зорилгоор энэхүү ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй 60 гүний худгийн уснаас сорьц авч физик-хими, бичил элементүүд, цацрагийн аюулгүйн үзүүлэлт болон бичил амь судлалын үзүүлэлтүүдээр чанарын судалгааг хийж гүйцэтгэсэн болно. Судалгаанд хамрагдсан гүний худгуудын ус нь сул хүчиллэг-саармаг-сул шүлтлэг орчинтой, зөөлнөөс зөөлөвтөр устай 51 худаг, хатуувтраас хатуу устай 9 худаг байгаа ба 17 гүний худаг нь гидрокарбонат-кальци, магнийн төрлийн, 43 худаг нь гидрокарбонат-кальци, натрийн төрлийн усанд хамаарагдаж байна. Уг гүний худгуудын усны химийн шинжилгээний үр дүнг Монгол улсад мөрдөж буй MNS 0900:2018 стандарттай харьцуулахад 7 худаг нитрат (NO_3^-) ионы агуулгаараа, 1 худаг стронцийн агуулгаараа, 2 худаг кальцийн (Ca^{2+}) ионы агуулгаараа тус тус стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн байгааг тодорхойлов. Мөн 17 гүний худаг бичил амь судлалын үзүүлэлтээрээ хангахгүй байгааг тодорхойллоо. Сүхбаатар дүүргийн ундны усны зориулалтаар ашиглаж буй 40 гүний худаг нь Монгол улсад мөрдөж буй MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна.

Түүл голын усны чанарын судалгаа: Түүл голын урсгалын дагуу Тэрэлжээс Төв аймгийн Лүн сум хүртэлх 10 цэгээс улирал тутам сорьц цуглуулан физик-химийн болон бохирдлын үзүүлэлтийг тодорхойлон, усны чанарын судалгааг явуулсны үндсэн дээр бохирдлын түвшинг тогтоон дүгнэлт өгөх зорилгоор энэхүү ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Голын эх буюу Тэрэлжийн бүс нэн цэнгэг усны ангилалд хамаарагдаж байсан бол Улаанбаатар хот орчмын бүсийн голын усны эрдэсжилт ойролцоогоор 1.2 дахин нэмэгдсэн байна. Харин Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир ус нийлсэн (Биокомбинатын Т6) цэгт голын усны эрдэсжилт болон бусад анион катион ихээхэн

нэмэгдэж байгаа боловч Лүнгийн бүсийн Т9, Т10 цэгт байгалийн усны өөрөө цэвэрших явцын дүнд нийт эрдэсжилт болон хатуулаг буурах зүй тогтол ажиглагдсан. Шим бохирдлын үзүүлэлт болох аммонийн азот, нитритийн азот, исэлдэх чанар, эрдэс фосфорын агуулга Тэрэлж, Улаанбаатар хотын бүсэд (Т1-Т5 цэгт) стандартын утгаас хэтрээгүй байсан бол Т6 цэгт огцом нэмэгдэж стандартын утгаас давсан байна. Харин Лүнгийн бүсийн Т9, Т10 цэгүүдийн хувьд шим бохирдлын үзүүлэлт урсгалын дагуу аажим буурч байгаа хэдий ч голын эхэн хэсэгтэй харьцуулахад гүйцэд цэвэрших процесс явагдаагүй нь харагдаж байна. Мөн Туул голын ус эхэн хэсэгтээ буюу Тэрэлж, Улаанбаатар хот орчмын бүсэд (Т1-Т5 цэг) “Маш цэврээс цэвэр” (I-II) усны ангилалд хамаарагдаж байсан бол Т6 цэгээс “Бохирдолтойгоос их бохирдолтой” буюу IV-V зэрэглэл рүү, харин Т7-Т10 цэгт усны чанар “Бохирдолтойгоос бага бохирдолтой” (III-IV) ангилал руу шилжиж буйг тогтоолоо.

Усны чанарын үзүүлэлтүүдийг таамаглахад хиймэл оюун ухаан (ANN)-ыг хэрэглэсэн үр дүн: Туул голын усны чанарыг таамаглах судалгааг ANN-ын тооцооллыг хийхдээ физик-химийн үзүүлэлтүүд хоорондын хамаарлыг ашигласан. Шинжилгээний дүнгээс харахад хлорид (Cl^-) нь цахилгаан дамжуулах чанар EC, нийт ууссан давс (TDS), нийт хатуулаг (TH), химийн хэрэгцээт хүчилтөрөгч (XXX), биологийн хэрэгцээт хүчилтөрөгч (BXX_5) болон нийт эрдэсжилттэй маш хүчтэй ($r=0.87-0.99$) буюу эерэг, PO_4^{3-} -тай хүчтэй ($r=0.51$) эерэг, SO_4^{2-} , NO_2^- ($r=0.42-0.49$) дунд зэргийн эерэг хамааралтай байна. Тиймээс EC, TDS, XXX, BXX_5 , $\text{Na}^+\text{+K}^+$, Ca^{2+} , Mg^{2+} , NH_4^+ , HCO_3^- , нийт хатуулаг болон эрдэсжилт үзүүлэлтүүдийг оролт болгон сонгосон. Харин BXX_5 нь EC, TDS, XXX, BXX_5 , $\text{Na}^+\text{+K}^+$, Mg^{2+} , NH_4^+ , HCO_3^- , Cl^- , PO_4^{3-} болон нийт эрдэсжилттэй маш хүчтэй ($r=0.7-0.96$) эерэг, Ca^{2+} ($r=0.93$)-тай дунд зэргийн эерэг хамаарлыг харуулж байна. Хлорид (Cl^-)-ын загварчлалын хувьд 11 оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, арван нейрон бүхий далд давхарга, нэг хувьсагчтай (CLLM 11-10-1) гаралтын давхаргаас бүрдэх LM алгоритмаар оновчтой болгосон ANN загварыг гүйцэтгэсэн. Харин ANN загвар нь 11 оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, 9 нейрон бүхий далд давхарга, нейрон бүхий гаралтын давхарга (CLBR 11-9-1) зэргээс бүрдэх BR алгоритмаар оновчтой болгосон. CLBR 11-9-1 нь хамгийн зөв Cl^- -н таамаглалыг загварчилсан нь харагдаж байна ($\text{MSE}=3.34$, $\text{R}^2=0.992$). BXX -ийн хувьд, 11 оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, 8 нейрон бүхий далд давхарга, нэг хувьсагчтай (BODLM 11-8-1) гаралтын давхаргаас бүрдэх LM алгоритмаар оновчлогдсон ANN загвар нь бусад загваруудаас илүү байсан. Харин 11 оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, 12 нейрон бүхий далд давхарга, нейрон бүхий гаралтын давхарга (BODBR 11-12-1) зэргээс бүрдэх BR алгоритмаар оновчлогдсон ANN загвар нь бусад загваруудаас илүү гарсан. BODBR 11-12-1 нь хамгийн зөв BXX -ийн таамаглалыг загварчилсан нь харагдаж байна ($\text{MSE}=41.603$, $\text{R}^2=0.92$).

Ерөнхий дүгнэлт

- ❖ Б, В-станцын эх үүсвэрийн гүний худгуудын ус нь саармаг орчинтой, гидрокарбонат, сульфат-кальци, сульфат-кальци, магни, гидрокарбонат-кальци, магнийн төрлийн холимог найрлагатай байгаа бөгөөд зарим худгууд нь кальци, нийт хатуулаг, фтор, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ стандарт утгаас давсан байгааг тодорхойлов.
- ❖ Б,В станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны усны жил, улирлын химийн шинжилгээний үр дүнгээр үндсэн бүтэц найрлага өөрчлөлтгүй байгаа хэдий ч ионуудын тоон утгын хувьд бага зэрэг зөрүүтэй байна. Энэ нь тухайн өдөр ажиллаж байгаа гүний худгийн усны найрлагатай шууд хамааралтай байгааг тодорхойлов.
- ❖ Мөн Б, В станцын эх үүсвэрүүдийн органик бүрэлдэхүүний хувьд ихэнх худгуудын усанд толуол, стирен болон ксилолын уламжлалууд илэрсэн ч стандартад заасан хэмжээнээс маш бага байгаа нь манай орны болон бусад улс орны стандартад заасан ЗДА-аас 10-25 дахин бага байгааг тогтоов.
- ❖ Гэр хорооллын иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгийн усны чанарын судалгаагаар Баянзүрх дүүргийн 55 гүний худгаас 25, Сүхбаатар дүүрэг 62 гүний худгаас 21, Баянгол дүүрэг 18 гүний худгаас 15 худгийн ус нь Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гаргасан улс орнуудын мөрддөг ундны усны стандарт шаардлагыг хангахгүй усыг унд ахуйдаа хэрэглэж байгааг тогтоов.
- ❖ Судалгаанд хамрагдсан Туул голын ус нь ТЦБ-н хаягдал бохир ус нийлсэн цэгт “Бохирдолтойгоос их бохирдолтой” буюу IV-V усны ангилалд хамаарагдаж байгаа нь ТЦБ нь ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэглээнээс гарсан хаягдал усыг цэвэрлэн MNS 4943:2015-н шаардлагыг хангасан усыг хүрээлэн буй орчинд нийлүүлж чадахгүй байгаа бөгөөд хүний хүчин зүйлээс голын усны бохирдол үүсч байгааг илэрхийлж байна. Лүнгийн Т9, Т10 цэгийн голын ус байгалийн усны өөрөө цэвэрших явцын дүнд бохирдлын түвшин буурч байгаа хэдий ч Тэрэлжийн Т1 цэгтэй харьцуулахад гүйцэд цэвэрших процесс явагдаж чадахгүй байгааг тодорхойлов.

**“Улаанбаатар хотын ундны усны гидрохимийн болон органик
бүрэлдэхүүний судалгаа” сэдэвт суурь судалгааны төсөлт ажлын
гүйцэтгэгчид**

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

Б.Амарсанаа /Шинжлэх Ухааны Паркийн
гүйцэтгэх захирал, доктор, (Ph.D)/

ТӨСӨЛТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИД:

Д.Оюунцэцэг /Экологийн химийн
лабораторийн эрхлэгч, Доктор (Ph.D)/, ЭШАА
О.Хүрэлдаваа Доктор (Ph.D), ЭШДэдА
Г.Одонтуяа ЭШДэдА, магистр
А.Цийрэгзэн ЭШДэдА, магистр
Б.Дариймаа ЭШДаА, магистр
Г.Дуламсүрэн ЭША, бакалавр
А.Ичинноров ЭША, бакалавр
З.Буянжаргал ЭША, бакалавр

Товчилсон үг

ШУА - Шинжлэх Ухааны Академи
ХХТХ - Хими, химийн технологийн хүрээлэн
УСУГ - Ус сувгийн удирдах газар
АНУ – Америкийн нэгдсэн улс
ЕХ – Европын холбоо
УБЦТС – Улаанбаатар баруун цахилгаан түгээх станц
ДЭМБ - Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага
ЕС (ЦДЧ) – Цахилгаан дамжуулах чанар
ОРР (ИАП) – Исэлдэн ангижрах потенциал
TDS - Нийт ууссан давс
ЗДА - Зөвшөөрөгдөх дээд агууламж
БХХ – Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч
ХХХ - Химийн хэрэгцээт хүчилтөрөгч
ПИЧ - Перманганатын исэлдэх чанар
ТН - Нийт хатуулаг
ОНУ - Органик нүүрсустөрөгч
ОМ - Органик матери
НОНУ(М) - Нийт органик нүүрсустөрөгч (матери)
БОНУ(М) - Байгалийн органик нүүрсустөрөгч (матери)
УОНУ(М) - Ууссан органик нүүрсустөрөгч (матери)
МОНУ(М) - Макро органик нүүрсустөрөгч (матери)
БЗОНУ(М) - Биологийн задралын органик нүүрсустөрөгч (матери)
ХДБ – Халдваргүйжүүлэлтийн дараах бүтээгдэхүүн
ТГМ - Тригалогент метан
НТГМ -
БЗД - Баянзүрх дүүрэг
БГД - Баянгол дүүрэг
СБД - Сүхбаатар дүүрэг
УЧИ - Усны чанарын индекс
ГУЦЗАН - Гадаргын усны цэврийн зэргийн норм
ТЦБ – Төв цэвэрлэх байгууламж
ANN - Хиймэл оюун ухаан (Artificial neural network)
SWAT - Хөрс, усны шинжилгээний хэрэгслүүд (Soil Water and Analysis Tools)
WASP - Усны чанарын шинжилгээний загварчлалын программ (Water Quality Analysis Simulation Program)

Суурь судалгааны төсөлт ажлын тайлангийн бүтэц

Энэхүү тайлан нь хэвлэлийн тойм, судалгааны объект, арга зүй, судалгааны үр дүн гэсэн бүтэцтэй 4 үндсэн бүлэг, 9 дэд бүлэгтэйгээр бичигдэж нийт 59 хүснэгт, 11 зураг, 45 графикаар илэрхийлж (үүнээс Үйлдвэрийн эх үүсвэрийн гүний худгуудын усны горимын судалгааны үр дүнгээр 9 хүснэгт, 4 график, 1 зураг; Б-станцын хлоржуулалтын дараах болон хэрэглэгчдийн усны чанарын судалгааны үр дүнгээр 7 хүснэгт, 7 график; Мах комбинатын эх үүсвэрийн гүний худгуудын горимын судалгааны үр дүнгээр 4 график, 8 хүснэгт; В-станцын хлоржуулалтын дараах болон хэрэглэгчдийн усны чанарын судалгааны үр дүнгээр 11 хүснэгт, 5 график; Б, В станцын органик бүрэлдэхүүний судалгаагаар 3 зураг, 4 хүснэгт, 5 график; Баянзүрх дүүргийн гэр хорооллын худгуудын усны чанарын судалгааны үр дүнгээр 1 зураг, 3 хүснэгт, 6 график; Баянгол дүүргийн гэр хорооллын худгуудын усны чанарын судалгааны үр дүнгээр 5 хүснэгт, 2 график; Сүхбаатар дүүргийн гэр хорооллын худгуудын усны чанарын судалгааны үр дүнгээр 2 хүснэгт, 5 график, Туул голын усны чанарын судалгааны үр дүнгээр 1 зураг, 4 хүснэгт, 3 график, Усны чанарын үзүүлэлтүүдийг таамаглахад хиймэл оюун ухаан (ANN)-ыг хэрэглэсэн үр дүнгээр 1 зураг, 3 хүснэгт, 4 график) 86 ном хэвлэл ашиглан монгол хэл дээр 140 хуудсанд багтаан бичив.

Гарчиг

ОРШИЛ	1
Төсөлт ажлын зорилго:	1
Төсөлт ажлын шинэлэг тал.....	2
Төсөлт ажлын ач холбогдол	2
Судлагдсан байдал	2
Судалгааны арга, зүй.....	3
I БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН ҮЙЛДВЭРИЙН (Б) БОЛОН МАХ КОМБИНАТЫН (В) ЭХ ҮҮСВЭРИЙН ГҮНИЙ ХУДГУУДЫН ГИДРОХИМИЙН СУДАЛГАА	10
1.1 Үйлдвэрийн эх үүсвэрийн ус хангамжийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа.....	12
1.2. Үйлдвэрийн эх үүсвэрийн Б-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн ундны усны гидрохимийн судалгаа.....	24
1.3. Мах комбинатын эх үүсвэрийн ус хангамжийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа.....	35
1.4. Мах комбинатын эх үүсвэрийн В-станцын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн усны гидрохимийн судалгаа.....	45
II БҮЛЭГ. ОРГАНИК БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУДАЛГАА	55
2.1. Судалгааны үр дүн, хэлцэмж.....	59
III БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН ЗАРИМ ДҮҮРГИЙН ГЭР ХОРООЛЛЫН ИРГЭДИЙН УНД, АХУЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАДАГ ГҮНИЙ ХУДГУУДЫН ГИДРОХИМИЙН СУДАЛГАА	65
3.1. Баянзүрх дүүргийн гэр хорооллын иргэдийн унд, ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудын усны гидрохимийн судалгаа	66
3.2. Баянгол дүүргийн гэр хорооллын иргэдийн унд, ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудын усны гидрохимийн судалгаа.....	73
3.3. Сүхбаатар дүүргийн гэр хорооллын иргэдийн унд, ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудын усны гидрохимийн судалгаа.....	78
IV БҮЛЭГ. ГАДАРГЫН УСНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА	83
4.1. Туул голын усны чанарын судалгаа	83
4.2. Усны чанарын үзүүлэлтүүдийн судалгаанд хиймэл оюуны ухаан (ANN)-д суурилсан загварчлалын аргыг ашигласан үр дүн	91
V. ДҮГНЭЛТ	97
VII. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	100
VI. ХАВСРАЛТ	а

ОРШИЛ

Нийслэл Улаанбаатар хот нь Хангай Хэнтий уулархаг мужид, Хэнтийн уулсын баруун өмнөд, шувтрах үзүүр болох Богд уулын ард эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн Туул голын өргөргийн дагуу чиглэсэн хөндийд оршино [1]. Улаанбаатар хот нь аж үйлдвэр, эдийн засаг, хүн амын өсөлтийн хувьд хурдацтай хөгжиж буй хотуудын нэг юм. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод хотжилт, барилгажилт нэмэгдэхийн хэрээр унд, ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээний усны хэрэгцээ эрс нэмэгдэж байна. Хотын хүн амын унд, ахуйн болон хэрэглээний усыг Туул голын дагуу 35-40 метрийн гүний дөрөвдөгчийн сэвсгэр хурдсад агуулагдах газрын доорх цэнгэг усаар хангадаг [2]. Энэ газрын доорх ус нь гадаргын устай гидравлик холбоотой тул голын экологийн нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс нь хотын хүн амын усан хангамж, усны чанарт шууд ба шууд бус замаар нөлөөлж болно.

Улаанбаатар хотын хүн ам Дээд эх үүсвэр, Гачууртын эх үүсвэр, Төвийн эх үүсвэр, Үйлдвэрийн эх үүсвэр, Мах комбинатын эх үүсвэр, Яармагийн эх үүсвэр, Нисэхийн эх үүсвэрээс унд, ахуй мөн үйлдвэрлэлийн хэрэгцээний усаа авдаг байна. 1956 онд нийслэл хотын ундны ус хангамжийн анхдугаар ээлжийн барилгажилтын зураг төслийг боловсруулан 1959 онд Дээд эх үүсвэр, төвийн эх үүсвэр, үйлдвэрийн районы эх үүсвэр, мах комбинатын эх үүсвэр ашиглалтад орж одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна [3]. 2012-2014 онд Улаанбаатар хотын ус хангамж, түүний дотор гэр хорооллын ус хангамжийг нэмэгдүүлж хүн амыг баталгаатай цэвэр усаар хангах зорилгоор Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар Гачууртын эх үүсвэрийг ашиглалтад оруулсан. Мөн Солонгос улсын “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2015 онд “Яармагийн ус хангамжийн эх үүсвэр”-ийг ашиглалтад оруулсан байна [4].

Иймээс ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгууд болон халдваргүйжүүлэлт хийсний дараа хэрэглэгчдэд хүрч байгаа ундны усанд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болох галогент нэгдлүүдийн судалгаа болон химийн найрлагын өөрчлөлтийг улирал, жилийн хөдлөл зүйн хамаарлаар нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Төсөл хэрэгжих хугацаанд Улаанбаатар хотын ус хангамжийн Үйлдвэрийн эх үүсвэр болон Мах комбинатын эх үүсвэрийн гүний худгууд, халдваргүйжүүлэлт хийсний дараах хэрэглэгчдэд хүрч буй усанд улирал, жилээс хамаарсан судалгааг явууллаа. Мөн Улаанбаатар хотын зарим дүүргийн гэр хорооллын иргэдийн унд, ахуйдаа хэрэглэж буй гүний худгуудад гидрохимийн судалгаа хийж, усны чанар, анги, төрлийг тодорхойлж, үр дүнг боловсруулан тайланд нэгтгэн оруулсан болно.

Төсөлт ажлын зорилго:

Улаанбаатар хотын ундны ус түгээгүүрийн Б (Үйлдвэрийн эх үүсвэр), В (Мах комбинатын эх үүсвэр) станцын гидрохимийн горимын судалгаа, гэр хорооллын гүний худгийн ус болон гадаргын усны химийн найрлагын шинж чанар түүнд агуулагдах органик бүрэлдэхүүн, хүнд металлын агуулгыг тодорхойлж, өөрийн болон олон улсын стандарттай харьцуулан дүгнэлт өгөх зорилготой.

Зорилт

- ❖ Улаанбаатар хотын ус түгээгүүрийн Б, В станцын ус болон түгээлтийн дамжлагаас улирал тутам дээж авч ундны усны чанарын үзүүлэлтүүд болон органик бүрэлдэхүүний судалгааг явуулж өөрийн орны болон олон улсын стандарттай харьцуулан дүгнэлт өгөх
- ❖ Улаанбаатар хотын сонгогдсон гэр хорооллын ундны усны зориулалтаар хэрэглэж буй гүний худгийн усны гидрохими, эрүүл ахуйн үзүүлэлт болон органик бүрэлдэхүүний судалгааг нарийвчлан явуулж үндэсний болон олон улсын стандарттай харьцуулан дүгнэлт өгөх
- ❖ Улаанбаатар хотын гадаргын усны физик-химийн найрлага, хүнд метал, бохирдлыг тогтоох судалгааг явуулж олон улсын стандарттай харьцуулан үнэлгээ өгөх

Төсөлт ажлын шинэлэг тал

Улаанбаатар хотын Үйлдвэрийн (Б-станц) болон Махын (В-станц) эх үүсвэрийн гүний худгууд, станцуудын халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдэд хүрсний дараах усны химийн найрлагын горимын судалгааг сар, улирал, жилээс хамааруулан судалж, 3 дүүргийн гэр хорооллын ард иргэдийн ашиглаж буй худгуудын усанд усны чанарын нарийвчилсан судалгаа явуулж, Туул голын усны чанар, бохирдлын зэргийг тооцоолон гаргаж үндэсний болон олон улсад мөрдөгдөж буй стандарттай харьцуулан дүгнэлт өгсөн нь энэхүү төсөлт ажлын шинэлэг тал болно.

Төсөлт ажлын ач холбогдол

Төсөлт ажлын хүрээнд гарсан судалгаа шинжилгээний үр дүнг энэ чиглэлийн судалгаа хийдэг судлаачид, мэргэжилтнүүд, ард иргэд гарын авлага, баримт материал болгон ашиглах шинжлэх ухаан, практикийн ач холбогдолтой. Мөн энэ судалгааны үр дүнг эх үүсвэрийн гүний худгууд, шугам хоолойн ус болон иргэдийн ашиглаж буй худгуудын усны чанар, химийн найрлагыг хянах, бусад хүчин зүйлээс шалтгаалан бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зэрэгт шинжлэх ухааны болон нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой.

Судлагдсан байдал

Ус нь аль ч улсын үндэсний баялагт зүй ёсоор ордог байгалийн үнэт баялаг юм. Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах, усны нөөцийг зохистойгоор ашиглах нь аливаа төрийн тулгуур бодлого, үндэсний аюулгүй байдлын нэн чухал асуудлын нэг билээ.

Улаанбаатар хотын хүн амыг Туул голын дагуу байрласан ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгууд буюу газрын доорх цэнгэг усаар станцуудаар дамжуулан хангадаг байна. Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн нөөцийн хайгуулыг 1969 болон 1980 онуудад ЗХУ-н мэргэжилтнүүд, 1993 онд Японы мэргэжилтнүүдтэй хамтран манай орны судлаачид гадаргын болон газрын доорх усанд гидрогеологийн хайгуулын бүрэн судалгаа хийж нөөцийг тогтоосон байдаг [4].

2011-2013 онд ШУА-ийн ХХТХ-ийн эрдэмтэн судлаачид болон УСУГ-ын Усны төв лабораторийн мэргэжилтнүүд хамтран Улаанбаатар хотын ус хангамжийн 4 станцын усны химийн найрлага, 2015-2017 онд ХХТХ-ийн судлаачид Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийн 7 станцын халдваргүйжүүлэлтийн өмнөх, дараах уснуудад гидрохимийн горимын судалгааг хийсэн байна. Энэхүү судалгаагаар Үйлдвэрийн районы эх үүсвэр буюу Б станцын ус, Мах комбинатын эх үүсвэр буюу В станцын уснуудын эрдэсжилт болоод анион, катионы агуулга бусад 5 станцын уснаас өндөр агуулгатай байгааг тодорхойлсон байна. Туул голын усны найрлагыг 1978 онд ЗХУ-н мэргэжилтнүүд судлан анионоос гидрокарбонат, катионоос кальци, кали давамгайлдаг байна гэж дүгнэсэн байдаг. 1977-1978 оны Улсын Эрүүл ахуй, Халдвар, Нян судлалын институт Усны аж ахуйн Яамны лабораториудад хийсэн шинжилгээгээр Туул голын усны урсгалын дагуу дээрээс доошлох тутам бохирдолт ихсэх ба хотын дээр Баянзүрхийн гүүр, Амгалангийн хэсэгт аммиак, нитрат, ХБХ, фенол, нефтийн бүтээгдэхүүний үзүүлэлтээр зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байгааг тодорхойлсон байна [5]. Мөн О.Алтансүх нар [6], Т.Энхжаргал нар [7], Т.Соёл-Эрдэнэ [8] нарын олон судлаачид Туул голын усны чанар, хүнд металлын агууламж, бохирдлын талаар судалгаа хийж, Э.Дандар [9] “Хүйтэн бүсийн усны нөөцийн үнэлгээ: Туул голын дээд сав газар”, Х.Бадарч [10] “Туул голын уртын дагуух урсцын хуваарилалт ба алдагдал” сэдвээр доктор болон магистрын зэрэг хамгаалж, ШУА-н ГГХ-ийн судлаачид Туул гол: Экологийн өөрчлөлт, усны менежментийн асуудал, “Туул голын газрын доорх усны тэжээгдлийн судалгаа ба бохирдлын мониторингийн үнэлгээ”, “Туул голын газрын доорх усны тэжээгдлийн судалгаа ба бохирдлын мониторингийн үнэлгээ” зэрэг төсөл судалгааны ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна.

ШУА-ийн ХХТХ, ГГХ болон Хот суурины ус хангамж, ариутгах татуургын зохицуулах зөвлөлтэй хамтран Улаанбаатар хотын 9 дүүргийн ундны усны чанарын судалгааг хийхдээ гэр хорооллын иргэдийн унд ахуйдаа хэрэглэж буй худгуудыг хамруулсан судалгааг 2019-2020 онд хийж гүйцэтгэсэн байна. Мөн Ч.Жавзан нар [11] “Улаанбаатар хот орчмын гэр хорооллын суурьшлын бүсийн газар доорх усны чанарын судалгааны зарим үр дүнгээс”, Г.Одонтуяа нар [2, 12] “Баянзүрх дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа”, “Сүхбаатар дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа”, Д.Гэрэлт-Од нар [13] “Улаанбаатар хотын ундны усны худгуудын физик-химийн шинж чанар”, Г.Дуламсүрэн нар [14] “Улаанбаатар хотын ундны усны зориулалтаар ашиглаж буй гүний худгуудын микробиологийн судалгаа, О.Хүрэлдаваа нар [15] “Хан-Уул дүүргийн гүний усны чанарын үнэлгээ”, Т.Энхжаргал [16] “Баянзүрх дүүргийн газрын доорх усны гидрохими болон чанарын үнэлгээ” зэрэг судалгааны өгүүлэл болон илтгэлүүдийг хэвлүүлсэн байна.

Судалгааны арга, зүй

Тайлангийн хугацаанд судалгаанд хамрагдсан ус хангамжийн эх үүсвэрийн гүний худаг, “Б, В” станцын халдваргүйжүүлэлтийн дараах ус, гэр хорооллын гүний худаг, гадаргын усны сорьцуудын орчин буюу рН-ийг НМ-30Р, цахилгаан дамжуулах чанар буюу (ЕС, mS/m)-ийг СМ-31Р маркийн дижитал термометрээр, исэлдэн ангиграх потенциал болох (ORP, mV), нийт ууссан давс буюу (TDS, ppm)-ийг multiparameter

Н198194 маркийн багажаар тус бүр хэмжилтийг хийв. Түүнчлэн лабораторийн шинжилгээний сорьцыг тухайн усны шинж чанарт тохируулан зааврын дагуу дээж авсан болно. Үндсэн катион, анион (ПИЧ, Ca^{2+} , Mg^{2+} , CO_3^{2-} , HCO_3^- , Cl^-)-г титрийн буюу эзлэхүүний аргаар, SO_4^{2-} -ийн ионыг жингийн аргаар, NH_4^+ , $Fe_{нийт}$, NO_3^- , NO_2^- , F^- , PO_4^{3-} ионыг S2100UV маркийн спектрофотометрээр тодорхойлов [17]. Микроэлементийн шинжилгээг SGS лабораторийн ICP-MS багажаар, цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг МУИС-н Цөмийн судалгааны төвд тус тус тодорхойлсон.

Бичил амь судлалын судалгааны арга зүй:

Усны чанарын биологийн аюулгүй байдлыг шалгах үндсэн арга нь бактериологийн буюу бичил амь судлалын үзүүлэлтийн хяналт байдаг. Унд, ахуйн усны хэрэгцээний нэгж эзлэхүүн усанд агуулагдах нийт нян, гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян зэрэг нь хүний биед халдвар дамжих аюулгүйн нөхцөлийг илэрхийлэгч үзүүлэлт болдог. Ундны усны аюулгүй байдлын гол илтгэгч үзүүлэлт нь *E.coli* бөгөөд энэ үзүүлэлт ундны усанд илэрвэл уг ус ялгадсаар бохирдсоны нотолгоо юм.

Энэ удаагийн төсөлт ажлын хүрээнд хамрагдсан сорьцод дараах стандарт арга зүйг ашиглан хүснэгт 1-т заагдсан 6 үзүүлэлтээр бичил амь судлалын шинжилгээг хийж гүйцэтгэв. Үүнд:

- MNS ISO 9308-1:1998 - Усны чанар. Гэдэсний бүлгийн бичил биетэн, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетэн болон, таамаглаж буй *E.coli* –г илрүүлэх ба тоолох, 1-р хэсэг: ялтаст шүүлтүүрээр шүүх арга
- MNS ISO 6222:1998 – Усны чанар. Амьдрах чадвартай бичил биетний тоог тогтоох - тэжээлт орчин дотор буюу гадаргад нь ургасан нянгийн бөөгнөрлийг тоолох
- MNS ISO 19250:2017- Усны чанар. Усан дахь салмонеллын төрлийн нянг илрүүлэх

Хүснэгт 1. Бичил амь судлалын үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 0900:2018 (ЗДА)
1	Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	тоо/100 мл	0
2	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	<i>Salmonella</i>	тоо/25 мл
3		<i>Shigella</i>	тоо/25 мл
4	Нийт нянгийн тоо	тоо/1 мл	<100
5	<i>E. coli</i>	тоо/100 мл	0
6	Халуунд тэсвэртэй гэдэсний нян	тоо/100 мл	0

Сорьц авах

Бичил амь судлалын шинжилгээний сорьцыг авахдаа нийт хийгдэх шинжилгээнд шаардагдах дээжний хэмжээг тооцон үзэж 500-550 мл авна. Сорьцын саван дээр хаяг, шошго, дугаар тавьж, солбицлын цэгийг тэмдэглэнэ. Сорьц авахдаа дараах заавруудыг мөрдөж авна.

- ИСО 3696:1987, шинжилгээний лабораторид ус-тодорхойлолт ба сорилын арга
- ИСО 5667-1: 1980, Усны чанар-Сорьц авах-1, сорьц төлөвлөх заавар
- ИСО 5667-2: 1982, Усны чанар-Сорьц авах-2
- ИСО 5667-3:1985, Усны чанар сорьц авах-3, сорьцыг зөөвөрлөх ба хадгалах заавар

Багаж, тоног төхөөрөмж

Усанд бичил амь судлалын шинжилгээ хийхэд дараах багажуудыг ашиглана. Үүнд:

- Хуурай халуунаар ариутгах хатаагч
- Автоклав
- Халуун тогтоогуур (37⁰С болон 42⁰С)
- рН метр
- Аналитик жин
- Ялтаст шүүлтүүрийн багажууд
- Ялтаст шүүлтүүр, ялтаст шүүрийн диаметр нь 47 мм буюу 50 мм нүхний голч 0.45 μ m
- Ариутгасан хямсаа
- Ариутгасан гогцоо зүү
- Спиртэн дэн
- Петрийн аяга
- Хэмжээст колбо
- Хуруу шил
- Тавиур шил

Судалгааны арга зүйг дараах дарааллаар хийж гүйцэтгэв. Үүнд:

Петрийн аяга болон бусад туслах материал бэлтгэх.

Шинжилгээнд хэрэглэгдэх петрийн аягыг сайтар угаах, урсгал ус болон нэрмэл усаар зайлах гэсэн дамжлагаар цэвэрлэнэ. Цэвэр петрийн аягыг хатааж пергамитэн цаасанд багц болгон боож 180⁰С-н хатаах шүүгээнд 2 цаг ариутгана. Бусад хуруу шил, колбо, ялтаст шүүлтүүрийг адил дамжлагаар бэлтгэнэ (Зураг 1).



Зураг 1. 1- Шил сав угаах хэсэг, 2- Угааж бэлтгэсэн шил сав хатаах, ариутгах, 3- Ариутгасан шил сав хадгалах хэсэг

Тэжээлт орчин бэлтгэх

Plate Count Agar: Нийт амьдрах чадвартай бактерийг тоолох стандарт тэжээлт орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 23.5 г орчинг нэмж уусган рН=7.0 болгож тохируулна. Бэлэн болсон тэжээлийг бага зэргийн буцалгах хүртэл давтамжтайгаар хөдөлгөн халаана. Дараа нь тохирох агууламж бүхий колбо эсвэл хуруу шилэнд тэжээлт орчинг савлана. Автоклавт 121⁰С температурт 15 минут ариутгана.

Endo Agar: Гэдэсний бүлгийн нян болон *Escherichia coli*-тодорхойлох сонгодог орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 42 г тэжээл нэмж уусгаж 5 мл Endo Basic fuchsin Solution (*EEEND20500*) Emulsion нэмж рН=7.0 болгож тохируулна. Бэлэн болсон тэжээлийг бага зэргийн буцалгах хүртэл давтамжтайгаар хөдөлгөн халаана. Дараа нь

тохирох агууламж бүхий колбо эсвэл хуруу шилэнд орчинг савлана. Автоклавт 121°C температурт 15 минут ариутгана.

SS agar: Грамм сөрөг бактери болон *Sallmonella*, *Shigella* тодорхойлох сонгомол тэжээлт орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 66 г тэжээлт орчинг нэмж уусган рН=7±0.2 болгож тохируулна. Бэлэн болсон тэжээлийг бага зэргийн буцалгах хүртэл давтамжтайгаар хөдөлгөн халаана. Автоклавт ариутгаж болохгүй!

Lactose Peptone Broth: *Escherichia coli*, лактоз задлах чадвартай бактери тодорхойлох баяжуулах орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 35 г тэжээлт орчинг нэмж уусган рН=7.2 болгож тохируулна. Дараа нь автоклавт 121°C температурт 15 минут ариутгана. Лактозтой орчныг 5°C температурт хадгална.

Peptone Water Buffered: *Sallmonella*, *Shigella* тодорхойлох баяжуулах орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 16 г тэжээлт орчинг нэмж уусган рН=7.0 болгож тохируулна. Шинжилгээнд шаардагдах хэмжээтэй тохирох агууламж бүхий колбо, хуруу шилэнд тэжээлт орчинг хуваарилна. Дараа нь автоклавт 121°C температурт 15 минут ариутгана. Буферын орчныг 5°C температурт хадгална.

Агар бүхий Петрийн аягыг бэлтгэх

Тэжээлт орчинг 47-50°C болгон хөргөн петрийн аяганд 20-25 мл савлан царцаана. Хэрэглэхийн өмнө гадаргуу бүрэн хатах хүртэл агар бүхий петрийн аягыг (агарын гадаргууг доош, тагийг дээш харуулан) тасалгаанд хатаана. Тэжээлт орчин хатаж, хагарахаас сэргийлж 5°C температурт хадгална. Бэлтгэсэн тэжээлт орчин тус бүрт эерэг хяналт тавьж баталгаажуулна (Зураг 2).



Зураг 2. 1- Тэжээлт орчин автоклавд ариутгах хэсэг, 2- Ариутгасан тэжээлт орчин савласан байдал, 3, 4-Тэжээлт орчин хадгалах хөргөгч

Шинжилгээ хийх явц

1. **Нийт нянгийн тоо:** Өвөрмөц тэжээлт орчинд тодорхой нөхцөлд нянгийн бөөгнөрөл үүсгэн ургаж чадах бүх төрлийн агаартан нянг илрүүлэх арга юм. Шинжилгээний сорьцоос 1 мл авч петрийн аяган дахь өвөрмөц тэжээлт орчинтой (Plate Count Agar) жигд болтол нь холих буюу царцаан 37°C температурын дулаан тогтоогуурт 24 цаг өсгөвөрлөнө. Хоёр аягатай тэжээлт орчны дотор болон дээр нь ургасан нянгийн бөөгнөрлийг колони тоолох багажны тусламжтайгаар тоолон үр дүнг гаргана.
2. **Гэдэсний бүлгийн бичил биет илрүүлэх, тоолох:** Шинжилгээний сорьцоос 100 мл авч ялтаст шүүрээр шүүсний дараа сонгомол (Endo agar), лактоз агуулсан шингэн орчин дээр 37°C болон 44°C тус бүрт 24 цаг ургуулан өсгөвөрлөнө. Үр

дүнг тооцохдоо ялтаст шүүрэн дээр ургасан тодорхой шинж тэмдэгтэй нянгийн бөөгнөрлийг тоолж, шаардлагатай тохиолдолд батлах сорилоор батална.

1. Гэдэсний бүлгийн бичил биетнүүд (coliform organisms): $35^{\circ}\text{C}+0.5^{\circ}\text{C}$ буюу $37^{\circ}\text{C}+0.5^{\circ}\text{C}$ -ийн аль нэгэнд сонгомол (Endo agar) ба лактозтой орчинд агаартай нөхцөлд 18+3 цагийн дотор лактозыг хүчил үүсгэн ургах чадвартай бичил биетэн юм.
2. Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетнүүд (Thermotolerant coliform organisms): $44^{\circ}\text{C}+0.25^{\circ}\text{C}$ буюу $44.5^{\circ}\text{C}+0.25^{\circ}\text{C}$ -ийн аль нэгэнд сонгомол (Endo agar) ба лактозтой орчинд агаартай нөхцөлд 18+3 цагийн дотор лактозыг хүчил үүсгэн ургах чадвартай бичил биетэн юм.
3. Байж болзошгүй нян *Escherichia coli*: $44^{\circ}\text{C}+0.25^{\circ}\text{C}$ буюу $44.5^{\circ}\text{C}+0.25^{\circ}\text{C}$ -ийн аль нэгэнд 24 цагийн дотор триптофанаас индол үүсгэдэг шинж чанартай лактозоос (буюу маннит) хий үүсгэн ургах чадвартай халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетэн юм [18].
3. *Салмонеллын төрлийн нянг илрүүлэх (Salmonella)*: $36^{\circ}\text{C}\pm 2^{\circ}\text{C}$ -д 18±2 цаг сонгомол баяжуулах тэжээлт орчинд (Peptone Water Buffered) баяжигдан, $36^{\circ}\text{C}\pm 2^{\circ}\text{C}$ -д 24±3 цаг сонгомол хатуу тэжээлт орчин (SS agar) дээр хэв шинжит онцлох колони үүсгэн өсгөвөрлөгдсөн, биохими ба ийлдэс судлалын аргаар тодорхойлогдсон бичил биетэн юм. Үр дүнг тооцохдоо биохимийн болон ийлдэс судлалын шинжилгээний баталгаажилтын үр дүнгээр *Salmonella* гэж таамаглаж байгаа эсэхийг харуулна.
4. *Шигелл төрлийн нянг илрүүлэх (Shigella)*: $36^{\circ}\text{C}\pm 2^{\circ}\text{C}$ -д 18±2 цаг сонгомол баяжуулах тэжээлт орчинд (Peptone Water Buffered) баяжигдан, $36^{\circ}\text{C}\pm 2^{\circ}\text{C}$ -д 24±3 цаг сонгомол хатуу тэжээлт орчин (SS agar) дээр хэв шинжит онцлох колони үүсгэн өсгөвөрлөгдсөн, биохими ба ийлдэс судлалын аргаар тодорхойлогдсон бичил биетэн юм. Үр дүнг тооцохдоо биохимийн болон ийлдэс судлалын шинжилгээний баталгаажилтын үр дүнгээр *Shigella* гэж таамаглаж байгаа эсэхийг харуулна [19].



Зураг 3. 1- Шинжилгээнд авсан дээж болон туслах материал 2- Шинжилгээ хийгдсэн үндсэн хэсэг (ламинар бокс), 3- Ялтаст шүүлтүүрийн багажууд, 4- Ялтаст шүүр

Органик бүрэлдэхүүн тодорхойлох арга: Зарим төрлийн хлорт болон хлорт бус дэгдэмхий органик нэгдлүүд болон тригалогент метаны шинжилгээг Varian (Agilent) GC-431, MS 240 загварын ион баригч хийн хроматографи, масс спектрометрийн төхөөрөмж ашиглан тодорхойлов.

Хүснэгт 2-д хийн хроматографи масс спектрометрээр тодорхойлох нэгдлүүдийн нэр, химийн томьёо болон таньц буюу үндсэн онош ионуудыг үзүүлэв [20].

Хүснэгт 2. Зарим галогент болон галогент бус органик нэгдлүүдийн масс спектрометрийн таньц ион

Нэгдэл	Томьёо	CAS №	Таньц ион 1	Таньц ион 2	Таньц ион 3
Винилхлорид	$\text{CHCl}=\text{CH}_2$	75-71-8	62	64	
Дихлорметан	CH_2Cl_2	75-09-2	49	51	
Трихлорметан	CHCl_3	67-66-3	85	87	83
1,1- дихлорэтен	$\text{CCl}_2=\text{CH}$	75-35-4	61	63	96
1,2- дихлорэтан	$\text{CH}_2\text{ClCH}_2\text{Cl}$	107-06-2	62	64	98
1,1,1- трихлорэтан	CCl_3CH_3	71-55-6	97	99	117
Трихлорэтилен	$\text{CCl}_2=\text{CHCl}$	79-01-6	95	130	97
Тетрахлорэтилен	$\text{CCl}_2=\text{CCl}_2$	127-18-4	166	168	129
Тетрахлорметан	CCl_4	56-23-5	117	119	121
Трибромметан	CHBr_3	75-25-2	173	171	91
Бромдихлорметан	CHBrCl_2	75-27-4	83	85	129
Дибромхлорметан	CHBr_2Cl	124-48-1	129	127	131
1,4-дихлорбензол	$\text{C}_6\text{H}_4\text{Cl}_2$	106-46-7	146	111	148
Бензол	C_6H_6	71-43-2	78	77	
Толуол	$\text{C}_6\text{H}_5\text{CH}_3$	108-88-3	91	92	
Стирен	C_8H_8	100-42-5	104	91	
Нафтален	C_{10}H_8	91-20-3	128	127	102
о-Ксилол	C_8H_{10}	95-47-6	91	106	105
м-Ксилол	C_8H_{10}	108-38-3	91	106	105
п-Ксилол	C_8H_{10}	106-42-3	91	106	105
Этилбензол	C_8H_{10}	100-41-4	91	106	-
МТБЭ	$\text{C}_5\text{H}_{12}\text{O}$	1634-04-4	73	57	41

Судалгаанд авсан эх үүсвэрүүдийн дээжийг тогтвортой уурын фазын шинжилгээний шилэн саванд хийж 70⁰C-ийн температурт халаан сэгсэрч дэгдэмхий шинж чанартай органик нэгдлүүдийг ууршуулан хий хроматографи масс спектрометрийн төхөөрөмж рүү шахав. Хийн хроматографийн масс спектрометрийн төхөөрөмжийн шинжилгээ явуулах нөхцөлийг дор дурдав:

240 – MS – масс спектрометр

- EI параметр 30uAmps
- Multiplier 70 Вольт
- Температур
 - Trap 150⁰C
 - Manifold 50⁰C
 - Transferline 190⁰C

431-GC – хийн хроматографи

- Зөөгч хийн урсгалын хурд 1 мл/мин-тогтмол
- Инжектор t⁰C 220
- Ramp: 35⁰C 2 мин 2 мин
- 160⁰C 10 C/мин 9.50 мин 24 мин
- 190⁰C 10 C/мин 8 мин 35 мин

Combiral – тогтвортой уурын фазын дээж авагч

- Шахах эзлэхүүн 1 ml headspace
- Тариурын t⁰C 65⁰C
- Халаагчийн t⁰C 70⁰C

- Халаагчийн сэгрэх хурд 500 rpm
- Сэгсрэх хугацаа 10 минут

Усны чанарын индекс: Гадаргын усны чанар, бохирдлыг усны орчин болон шим бохирдлын үзүүлэлтүүдээр тооцож “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS 4586:1998” болон Байгаль Орчны сайд, Эрүүл Мэндийн сайдын 1997 оны 143/А-352 тоот тушаалаар баталсан “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм (ГУЦЗАН)” (хүснэгт 3)-той харьцуулан үнэлгээ өгч, бохирдлын түвшинг тогтоосон [21, 22]. Усны чанарын индекс (УЧИ)-ийн тархалтын зураглалыг Arc-GIS 10.4 программ ашиглан үзүүлэв.

$$УЧИ = \frac{\sum \left(\frac{C_i}{PL_i} \right)}{n} \quad (1)$$

УЧИ - Усны чанарын индекс
 C_i - Үзүүлэлтүүдийн агуулга
 PL_i - Үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ
 n – Нийт үзүүлэлтүүдийн тоо

Хүснэгт 3. Гадаргын усны чанарын ангилал

УЧИ	Усны чанар		Хэрэглээ, цэвэрлэх боломж
	Зэрэг	Ангилал	
≤ 0.30	I	Маш цэвэр	Цэвэршүүлэх шаардлагагүй бөгөөд бүх төрлийн хэрэгцээнд ашиглахад тохиромжтой.
0.31 - 0.89	II	Цэвэр	Цэвэршүүлсний дараа унд болон хүнсний үйлдвэрлэлд хэрэглэж болно. Харин цэвэршүүлэлт явуулахгүйгээр загасны аж ахуйд шууд хэрэглэхэд тохиромжтой.
0.90 - 2.49	III	Бага бохирдолтой	Унд болон хүнсний үйлдвэрлэлд тохиромжгүй. Хэрвээ усны өөр эх үүсвэр байхгүй бол цэвэршүүлсний дараа хэрэглэж болно. Харин цэвэршүүлэлт явуулаагүй үед мал аж ахуй, амралт зугаалгын газрын цөөрөм, усан бассейны зориулалтаар ашиглах боломжтой .
2.50 - 3.99	IV	Бохирдолтой	Тохиромжтой цэвэршүүлэлт хийсний дараа усалгаа болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломжтой.
4.00 - 5.99	V	Бохир	Тохиромжтой цэвэршүүлэлт явуулсны дараа бие махбодод хүрэхгүйгээр хүнд үйлдвэрт хэрэглэнэ.
≥ 6.00	VI	Маш бохир	Бүх төрлийн хэрэгцээнд хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд олон шат дамжлага бүхий цэвэршүүлэлт хэрэгтэй.


I БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН ҮЙЛДВЭРИЙН (Б) БОЛОН МАХ КОМБИНАТЫН (В) ЭХ ҮҮСВЭРИЙН ГҮНИЙ ХУДГУУДЫН ГИДРОХИМИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хотод хүн амын өсөлт, хотжилт эрчимтэй явагдаж байгаатай холбоотойгоор хүний болон техноген процессын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын доорх усны төлөв байдалд өөрчлөлт орох эрсдэл ихээхэн үүсээд байна. Ялангуяа хүний үйл ажиллагаа, төлөвлөлтгүй суурьшил болон барилгажилт зэргийн нөлөөгөөр газрын доорх усны тэжээгдэлт, солигдолт, шилжилт хөдөлгөөн, усны чанар найрлагад өөрчлөлт орж болзошгүй байна.


Ундны усыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх зорилгоор төвлөрсөн ус түгээлтэд дэлхий нийтээр түгээмэл хэрэглэдэг халдваргүйжүүлэлтийн нэг арга болох хлоржуулалтыг манай улс ашигладаг байна. Манай оронд анх ундны усыг 1965 оноос хлоржуулж халдваргүйжүүлэлт хийж эхэлсэн бөгөөд ундны усны стандартыг 1978 онд баталж одоог хүртэл 5 удаа шинэчилсэн байна [23]. Хлоржуулалтын үед хлорын тунг зөвөөр тогтоох нь чухал бөгөөд тухайн усны шинж чанарыг тодорхойлох туршилтуудын үндсэн дээр тохируулах ёстой. Улаанбаатар хотын ус түгээлтийн системд хлоржуулах тунг 1960-1970-аад оны үед ОХУ-д мөрддөг журмын дагуу тогтоож одоог хүртэл мөрдлөг болгодог байна [24]. Бид энэхүү төсөлт ажлын хүрээнд Улаанбаатар хотын ус хангамжийн Үйлдвэрийн болон Махын эх үүсвэрийн гүний худгууд, халдваргүйжүүлэлт хийсний дараах хэрэглэгчдэд хүрч буй усанд 2019-2022 онд гидрохимийн судалгаа явуулж улирал, жилийн хөдлөл зүйн хамаарлыг тогтоох горимын судалгааг явуулсан болно.

Судалгааны объект

Суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуй нэгжийг цэвэр усаар хангадаг Үйлдвэрийн эх үүсвэрийн 16 гүний худаг, Б-станцын халдваргүйжүүлэлтийн дараах эхний болон эцсийн хэрэглэгчдэд хүрч буй 4 цэг, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн хэрэглэгчдийг усаар хангадаг Мах комбинатын эх үүсвэрийн 11 гүний худаг, В-станцын халдваргүйжүүлэлтийн дараах эхний болон эцсийн хэрэглэгчдэд хүрч буй 8 цэгээс 2020-2022 онуудын I-IV улирлуудад сорьц цуглуулан гидрохимийн судалгааг явуулсан болно. Судалгаанд хамрагдсан ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгууд, станц болон хэрэглэгчдийн байршлыг зураг 4, 5-д үзүүлэв.



Зураг 4. Үйлдвэрийн эх үүсвэрийн ус хангамжийн гүний худагууд болон хэрэглэгчдийн байршил



Зураг 5. Мах комбинатын эх үүсвэрийн ус хангамжийн гүний худагууд болон хэрэглэгчдийн байршил

1.1 Үйлдвэрийн эх үүсвэрийн ус хангамжийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа

Үйлдвэрийн эх үүсвэрийн Б-станц нь анх 1964 онд ашиглалтад орж Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд байрлах үйлдвэрүүд, орон сууц, албан газруудыг усаар хангаж ирсэн байна. Эх үүсвэрийн гүний худгууд нь тус дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт оршдог, 28-50 метр гүнтэй, 1963-1980 онд өрөмдөж гаргасан байна. Б станц нь эдгээр 16 гүний худгаас ээлжлэн ус татаж 1 өргөлтийн насос станцаар дамжуулан хэрэглэгчдэд түгээдэг байна [4]. Суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Үйлдвэрийн бүсийн Б-станцын ус хангамжийн эх үүсвэрийн 16 гүний худгаас 2019-2022 онд сорьц цуглуулж гидрохимийн судалгааг явуулсан болно. Ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгууд нь харуул хамгаалалттай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.1-д заасны дагуу эрүүл ахуйн хамгаалалтын шаардлага хангасан хашаатай байна. Сорьц цуглуулсан худгуудын байршлыг хүснэгт 4-д үзүүлэв.

Хүснэгт 4. Эх үүсвэрийн гүний худгуудын байршил, зураг

Монгол улсын хувьд хамгийн анх хлор ашиглаж халдваргүйжүүлэх аргыг 1959 онд Улаанбаатар хотын ундны усан хангамжид 50л-ийн бортоготой шингэн хлор ашигласнаар эхэлсэн бөгөөд цаашид хийн хлор, хуурай хлор зэргээс гадна 2014 оноос эхлэн электролизийн аргаар хоолны давснаас шингэн хлор гарган авч халдваргүйжүүлэлтэндээ ашиглаж байна.

Хлор ашиглан халдваргүйжүүлэх аргыг бид хагас зууны турш ашиглаж байгаа хэдий ч халдваргүйжүүлэлтийн дараах бүтээгдэхүүнүүд, түүний дотроос галогент органик нэгдлүүдийг тодорхойлох нь өнөөдрийн тулгамдсан асуудлуудын нэг болсон бөгөөд үүнийг тодорхойлох зорилгоор энэхүү ажлыг гүйцэтгэсэн.

Усанд агуулагдах органик нэгдлүүд: Усан дахь органик бодисууд нь ургамал болон бичил биетний үлдэгдэл тэдгээрийн задралаас үүсэн бий болдог. Ургамал тэдгээрийн задрал нь хөрсөн дээр явагдаж цаашид хөрс болон усанд нэвчдэг. Ургамал болон бичил биетнүүд нь ус, хөрсөнд ихээр байх ба тэдгээр нь үхэхэд био массын

хэмжээ өндөрсөж органик материйн хэмжээг ихэсгэдэг. Органик материйг дараах байдлаар ангилдаг:

- ОНУ- Органик нүүрсустөрөгч
- ОМ- Органик матери
- НОНУ(М)- Нийт органик нүүрсустөрөгч (матери)
- БОНУ(М)- Байгалийн органик нүүрсустөрөгч (матери)
- УОНУ(М)- Ууссан органик нүүрсустөрөгч (матери)
- МОНУ(М)- Макро органик нүүрсустөрөгч (матери)
- БЗОНУ(М)-Биологийн задралын органик нүүрсустөрөгч (матери)

Усан дахь органик бодисууд нь ууссан, коллоид, жинлэгдэх хэлбэрээр байх ба тодорхой динамик системийн дор хими, физик болон биологийн хүчин зүйлээс хамааран нэг төлөвөөс нөгөө төлөвт тасралтгүй шилжиж байдаг.

Мөн усанд агуулагдах органик нэгдлүүд нь эх үүсвэр, газарзүй болон гидрогеологийн бүтцээсээ хамаарч янз бүр байж болно. Усанд байх ууссан болон уусаагүй органик бодисын жижиг хэсгүүд хаа сайгүй байх ба тэдгээр нь намаг болон замагтай усанд шаргал бор өнгө үзүүлдэг байна.

Гүний усан дахь байгалийн органик бодис: Гүний усан дахь органик бодис нь физик-географикийн хүчин зүйлээс гадна давхаргаасаа хамааран хувирал болон тоо хэмжээ нь өөр өөр байж болно. Хөрсний ус, артезианы усан сангийн дээд хэсгийн хөндлөн босоо судалд байрлах сүвэрхэг хад чулуулаг болон агаар нэвтрүүлэх хэсэгт механик саатал ба коагуляцийн адсорбци явагддаг учир органик бодис багасдаг [30]. Гүний цэвэр усанд тохиолдож болох органик нэгдлүүдийн ангиллыг зураг 6-д үзүүлэв.



Зураг 6. Гүний усанд агуулагдах органик бодисууд болон тэдгээрийн төрөл

Гүний усан дахь органик нэгдлүүдийг дан хэлбэрээр (жишээлбэл янз бүрийн хүчлүүд – цууны, шоргоолжны г.м.) болон бүлгээр нь (битум, давирхай болон гумусын бодис г.м.) тодорхойлж болно. Гүний усан дахь бага молекултай органик хүчлүүд нь (цууны, шоргоолжны) усны ууртай хамт хэдэн долиос хэдэн арван мг/л-ийн хэмжээтэй байж болно. Мөн адил гумусын бодис, өндөр молекулт органик хүчлүүд (оксикарбоны – сүүний, алимны, лимоны; кетохүчлүүд – усан үзмийн; дикарбоны – хурган чихний, хувын), нүүрсус, аминхүчлүүд, спиртүүд, альдегидууд болон дэгдэмхий, дэгдэмхий бус органик нэгдлүүд байна.

Гумусын бодис нь цаашаа нарийн төвөгтэй зохион байгуулалттай өндөр молекулт гумин хүчил болон фулвик хүчил болон задардаг. Эдгээр нэгдлүүд нь карбоксил -COOH бүлэг голчилдог учир хүчиллэг шинжийг үзүүлэхээс гадна гидроксил -OH, метокси -OCH₃ болон карбоксил -CO бүлгүүдтэй байдаг.

Эрдэсжилт багатай гүний цэвэр усанд $C_{орг}$ органик бодисын бүлгээр нь тодорхойлбол дэгдэмхий бус 15-25%, дэгдэмхий суурьтай болон саармаг нэгдлүүд 55-70%, дэгдэмхий хүчлүүд 15-20%–ийг ойролцоогоор эзэлдэг байна. Үүнээс үзэхэд агуулагдаж буй органик нэгдлийн бараг хагас хувь нь дэгдэмхий эфирүүд, дэгдэмхий бага молекултай спиртүүд, дэгдэмхий аминууд г.м. дэгдэмхий суурьтай болон саармаг нэгдлүүд эзэлдэг байна. Дэгдэмхий бус бодисууд нь (давирхай, гумусын бодис, битум, өндөр молекулт органик хүчлүүд, дэгдэмхий бус фенолууд, нүүрсус, аминхүчлүүд г.м. болон бусад) 15-25% эзэлдэг хэдий ч гүний усанд байнга байдаг тогтвортой оршдог органик бодисууд болно.

Байгалийн органик бодисыг тодорхойлох ихэнх шинжилгээний арга нь нийт органик нүүрстөрөгчийн агуулгаар нь тодорхойлдог. Мөн багажит анализын аргууд болох ЦСР-ын арга, ХУ туяаны спектрофотометрийн арга нь тухайн нэг органик бодисын молекул бүтцийг гаргахаас бус нийт органик бодисыг тодорхойлоход учир дутагдалтай. Органик нэгдлийн ерөнхий агууламжийг перманганат кали, бихромат кали зэрэг эзлэхүүний аргуудаар тодорхойлж болдог. Энэ арга нь ууссан органик нэгдлийн тоо хэмжээг тодорхойлоход мөн адил дутагдалтай бөгөөд түүний нийт агуулгын 25-50%-ийг перманганат калиар исэлдүүлдэг байна. Учир нь энэхүү аргын исэлдэх чадварын тодорхой хувьд нь хоёр валенттай төмөр, хүхэртүстөрөгч, нитрит болон сульфид нөлөөлдөг бөгөөд эдгээр нэгдлүүдийг гарсан исэлдлийн утгаас (мг О/л) заавал хасаж (1мг H₂S-ийн 0.47 мг, 1мг NO₂⁻-ийн 0.35 мг, 1мг Fe²⁺-ийн 0.14 мг нь исэлдэхэд оролцоно) тооцдог. УОНУ-ийг бихромат калийн (K₂Cr₂O₇) аргаар хүхрийн хүчлийн орчинд тодорхойлоход ууссан органик бодисыг 95-98% исэлдүүлнэ. Зарим тохиолдолд гүний усан дахь ууссан органик бодисыг тодорхойлохдоо БХХ-биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн аргыг ашигладаг бөгөөд исэлдүүлэлтийг бичил биетний тусламжтай явуулдаг. Усанд амархан исэлддэг органик бодис байгаа тохиолдолд ХХХ болон БХХ ялгаатай гарч болно. Хэрвээ амархан исэлддэг органик бодис байхгүй тохиолдолд ХХХ болон БХХ ойролцоо гарч болно [31].

Халдваргүйжүүлэлтийн дараах галогент органик нэгдлүүд: Халдваргүйжүүлэлтийн дараах бүтээгдэхүүнүүд нь гол төлөв халдваргүйжүүлэхэд хэрэглэдэг бодисуудаас ихээхэн шалтгаалдаг байна. Хлор ашиглаж байгаа тохиолдолд хлорт органик нэгдлүүд үүсэх ба озоноор халдваргүйжүүлэх үед

альдегидийн бүлгийн нэгдлүүд үүсэх магадлалтай. Иймд эдгээр органик нэгдлүүд үүсэхэд олон хүчин зүйлүүд нөлөөлдөг байна. Үүнээс хамгийн чухалд тооцогдох нөлөөллүүдийн нэг нь бромидийн ион багтдаг бөгөөд хлор болон бромын холимог нэгдлүүдийг үүсгэхэд нөлөөлдөг байна.



Усанд бромид Br^- байхгүй тохиолдолд зөвхөн хлорт органик нэгдлүүд үүснэ. Хэрвээ байгаа тохиолдолд чөлөөт хлор бромтой хурдан исэлдэж гипобромын хүчлийг (HOBr) үүсгэдэг бөгөөд цаашид HOCl болон байгалийн органик бодисуудтай урвалд орж хлор бромын холимог халдваргүйжүүлэлтийн дараах бүтээгдэхүүнүүдийг үүсгэдэг [32]. Ундны усанд агуулагдах органик бодисуудыг бүгдийг нь авч үзнэ гэдэг тийм ч амар зүйл биш учир үйлдвэрлэлийн гаралтай зарим органик бодисууд болон халдваргүйжүүлэлтийн дараа үүсэж болох галогент органик нэгдлүүдийг хүснэгт 39-д үзүүлэв.

Хүснэгт 39. Халдваргүйжүүлэлтийн дараа үүсэж болох галогент органик нэгдлүүд

Халдваргүйжүүлэгчид	Хлор, гипохлорит ион, хлорын диоксид, хлорат ион, хлорамин
ТГМ-ууд	Хлорформ, бромформ, дибромхлорметан, бромдихлорметан
Хлоржуулалт/ хлорамины дараах бүтээгдэхүүнүүд	Галогент цууны хүчил, галогент кетонууд, хлорал гидратууд, МХ-2, фуранон, Н-органохлорамин
Галогент цууны хүчил	Монохлорт цууны хүчил(МСАА), ди (ДСАА) болон трихлорт цууны хүчил (ТСАА), Монобромт цууны хүчил (МВАА), дибромт цууны хүчил (ДВАА)
Озонжуулалтын дараах бүтээгдэхүүнүүд	Альдегид, эпоксид, пероксид, нитрозамин, бромат, иодат
Галогент цууны нитрилүүд	Бромхлорт цууны нитрил, дихлор цууны нитрил, дибром цууны нитрил, трихлор цууны нитрил

Ундны усыг зарим органик бодисууд, хлор болон озоноор халдваргүйжүүлэх үед үүсэх урвалын бүтээгдэхүүнүүдийн төлөөллийг хүснэгт 40-д үзүүлэв.

Хүснэгт 40. Хлор болон озоноор халдваргүйжүүлэх үед үүсэх урвалын бүтээгдэхүүнүүд


Хлор болон озоноор халдваргүйжүүлэх үед үүсэх урвалын бүтээгдэхүүнүүд				
Нэгдэл	Халдваргүйжүүлэгч		Бүтээгдэхүүн	
	Хлор	Озон	Хлор	Озон
Алканууд	0	0	0	0
Алканууд	1	2	Хлоргидрин	Альдегид
Ароматик нүүрсүтөрөгчид				
Толуол	0	0	0	0
м-ксилол	0	0	0	0
о/п-ксилол	0	0	0	0
Нафтален	0	2	0	Фталын хүчил
Флюорин	0	1	0	Флюорин-9-он
Пенантин	0	2	0	?
Флюорантен	0	2	0	?
Пирин	1	2	Хлоргидрин	?
Тосны хүчлүүд				
Октаноик	0	0	0	0
Деканоик	0	0	0	0
Додеканоик	0	0	0	0

Тетрадеканойк	0	0	0	0
Гексадек-9-аноик	2	2	Хлоргидрин	Гептанал
				Гептаны хүчил
				9-оксаноний хүчил
				Нонадионы хүчил
Гексадеканоик	0	0	0	0
Гептадеканоик	0	0	0	0
Октадек-9, 12-дионоик	2	2	Бис хлоргидрин	Гексаналь
				Гексаны хүчил
				9-оксаноний хүчил
				Нонадионы хүчил
Октадеқдиони	0	0	0	0
Эфирүүд				
Дибутилын адипати	0	-	0	-
Метил гексадек 9-еноат	2	-	chlorohydrin	-
Дибутилын фталат	0	-	0	-
Метил октадек 9- еноат	2	-	chlorohydrin	-
Метил октадекеноат	0	-	0	-
Трис (бутоксиэтил) фосфат	0	-	0	-
Диоктилфталат	0	-	0	-
Ионы бус гадаргуугын идэвхит бодис				
НП6	1	-	Бромын уламжлал	-
НП7	1	2	Бромын уламжлал	?
НП8	1	-	Бромын уламжлал	-
Катионт гадаргуугын идэвхит бодис				
Praragen WKT ханаагүй нэгдлүүд	2	2	Галогент гидрин	альдигид, карбоксилын хүчил, 'дөрөвдөгч' карбоксилын хүчил
Ханасан нэгдлүүд	0	0	0	0
Arquad 2HT	0	0	-	-
Цителпиридинеум	0	0	-	-
Анионт гадаргуугын идэвхит бодис				
SDBS	0	0	-	-
Пирметрин				
Цис	0	2	0	?
Транс	0	2	0	?


- 0- Урвал явагдаагүй
1- Хэсэгчлэн урвалд ордог
2- Бүрэн болон их хэмжээгээр урвалд ордог
?- Урвалын бүтээгдэхүүнийг тодорхойлоогүй
- тодорхойлоогүй

2.1. Судалгааны үр дүн, хэлцэмж

Улаанбаатар хотын ус хангамжийг үйлдвэр, мах комбинатын 2 станц, эх үүсвэрийн гүний худгууд болон хэрэглэгчдийн ундны усны органик бүрэлдэхүүний шинжилгээний дүнг “Хүрээлэн буй орчин. Эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт” MNS 0900:2018, ДЭМБ, Европын холбоо болон зарим улс орнуудын стандарттай харьцуулав. Б, В станц болон 1 хэрэглэгчийн усанд зарим төрлийн галогент ба галогент бус органик нэгдлүүдийг төлөвлөсөн арга аргачлалын дагуу тодорхойлон хроматограмыг зураг 7, 8-д үзүүлэв.



Зураг 7. Үйлдвэрийн Б – станцын хроматограм



Зураг 8. В – станцын хроматограм

Шинжилгээний дүнгээс харахад хамгийн их илэрдэг нэгдлүүд нь хлорформ бөгөөд үүний дараа бромдихлорметан, дибромхлорметан болон бромформ орж байна. Эдгээр нэгдлүүдийг манай орны ундны усны чанарын стандарт 0900:2018-д ЗДА-ыг заасан байдаг бөгөөд шинжилгээгээр илэрсэн нэгдлүүд нь стандартаас хэтрээгүй байна. Мөн түүнчлэн гарал үүслийн хувьд харилцан адилгүй органик бүрэлдэхүүн тодорхойлогдсон хэдий ч халдваргүйжүүлэлтийн дүнд үүсдэг органик нэгдлүүд болон байгалийн гаралтай буюу түлшний гаралтай органик нэгдлүүд агуулгын хувьд маш бага хэмжээгээр илэрсэн. Харин 2 эх үүсвэрийн хувьд органик бүрэлдэхүүний давхцал бий ч бромт уламжлал болон этилены уламжлалуудын хувьд эрс ялгаатай байгаа нь

харагдаж байна. Энэ нь хөрс, усны үндсэн бүтэц болоод геологийн тогтцын хөдөлгөөнт өөрчлөлттэй холбоотой байж болох талтай. Гүний усны байгалийн өгөгдөл нь физик-географикийн хүчин зүйлээс гадна давхаргаасаа хамааран хувирал болон тоо хэмжээ нь өөр өөр байдагтай холбоотойгоор артезианы усан сангийн дээд хэсгийн хөндлөн босоо судалд байрлах сүвэрхэг хад чулуулаг болон агаар нэвтрүүлэх хэсэгт механик саатал болон коагуляцийн адсорбци явагддаг учир 2 эх үүсвэрийн зарим худгуудад органик бодис багассан нь ажиглагдаж байна.

Гүний усан дахь органик нэгдлүүдийг дан хэлбэрээр, янз бүрийн хүчлүүд болон бүлгээр, битум, давирхай, гумусын бодисоор тодорхойлоход дэгдэмхий ба дэгдэмхий бус органик нэгдлүүд зонхилж байв. Тэр дундаа ароматик нэгдлүүд харьцангуй ихээр илрэх төлөвтэй байна. Харин гүний усанд багагүй агуулагддаг бага молекултай органик хүчлүүд, гумусын бодис, өндөр молекулт органик хүчлүүд, нүүрс ус, аминхүчлүүд, спиртүүд болон альдегидууд нь ашигласан хандалтын аргад хандлагдаагүй бөгөөд энэ арга нь тохиромжтой бус болох нь харагдав. Б, В станцын эх үүсвэрийн худгуудын усны 2021, 2022 оны органик бүрэлдэхүүний дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 1-1а, 2-2а-д тус тус үзүүлэв.




График 21. Б, В станц хэрэглэгч, гүний худгийн усны органик бүрэлдэхүүн, 2021 он

Б, В станцын халдваргүйжүүлэлтийн дараах усны органик нэгдлүүдийн шинжилгээний дүнг MNS 0900:2018, ДЭМБ, Европын холбоо, АНУ-ын ундны усны удирдамжид заасан ЗДА-тай харьцуулан хүснэгт 41-д үзүүлэв.

Хүснэгт 41. Б. В станцын халдваргүйжүүлэлтийн дараах усны органик нэгдлүүдийн хэмжээ, мкг/л, (2022 он)

№	Нэгдэл	MNS 900:2018 (ЗДА)	ДЭМБ	ЕХ	АНУ	Б станц	В станц
1	Этилбензол	300	300	С3	700	-	0.22
2	Стирен	20	20	С3	100	0.256	-
3	о-Ксилол	500	500	500	10000	-	-
4	м-Ксилол					0.22	0.217

5	п-Ксилол					-	-
6	Бензол	10	10	1	5	-	-
7	Толуол	700	700	C3	1000	74.69	3.067
8	МТБЭ					-	0.11
9	Хлорформ	200	200	100	80	6.477	2.879
10	Бромдихлорметан	60	60			12.021	0.455
11	Дибромхлорметан	100	100			20.433	1.8
12	Бромформ	10	100			0.38	2.8
13	1,2-дихлорэтан	-	30		5	-	-
14	1,1-дихлорпропен	-				0.153	-
15	Тетрахлорметан	-	4	C3	5	-	0.927
16	1.1.1-трихлорэтан	70			200	-	-
17	1.4-Дихлорбензол	-	300	C3	75	-	-
18	Тетрахлорэтилен	-	40	10		10.34	14.147
19	Трихлорэтилен	-	40	10	5	10.694	31.636
20	1.2-дихлорэтен	20	50	C3	100	11.338	0.559
21	Дихлорметан	-	20		5	-	-
22	Винилхлорид	0.3	0.3	0.5	2	0.29	-
23	Изопропилбензол	-				-	0.141
24	п-Изопропилтолуол	-				0.188	0.223
25	1,3,5-Триметилбензол	-				0.138	-
26	Нафтален	-				0.146	66.5

Тайлбар: Органик нэгдлүүдийг тодорхойлсон дэлгэрэнгүй үр дүн хавсралт -д үзүүлэв.

Улаанбаатар хотын Б станц болон эх үүсвэрийн №1, 7, 8, 9, 10, 16-р гүний худгийн усны органик бүрдлүүдийн найрлагыг галогент ба галогент бус органик нэгдлүүдийн масс спектрометрийн таньц ион тархалтыг график 22-т үзүүлэв.




График 22. Б станцын эх үүсвэрүүдийн органик бүрэлдэхүүний найрлага, мкг/л.

Харин түлшний гаралтай нэгдлүүд болон бензол, толуол, этилбензол, ксилолын уламжлалууд бараг илрээгүй болно. Зарим худгийн усанд толуол болон ксилолын уламжлалууд илэрсэн ч стандартад заасан хэмжээнээс маш бага байна.




График 23. В станцын эх үүсвэрүүдийн органик бүрэлдэхүүний найрлага, мкг/л.

Харин Улаанбаатар хотын В станц болон эх үүсвэрийн №1, 2, 3, 4, 5, 6, 8, 9, 10, 11 дүгээр гүний худгийн усны органик бүрэлдэхүүний найрлагыг галогент ба галогент бус органик нэгдлүүдийн масс спектрометрийн таньц ион тархалтыг график 22-т үзүүлэв. Графикаас харахад түлшний гаралтай нэгдлүүд болон бензол, толуол, этилбензол, ксилолын уламжлалууд бага зэрэг илэрч байгаа нь тодорхой бохирдолтой байгаа хэдий ч MNS стандарттай харьцуулахад ойролцоогоор 10-100 дахин бага агуулгатай байна. Цаашид ундны усанд үйлдвэрийн гаралтай органик бүрэлдэхүүний агуулгыг давтамжит хугацаагаар мониторинг хийж судлах нь учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Харин Б, В станцын эх үүсвэрийн зарим худгуудад толуол, стирен болон ксилолын уламжлалууд илэрсэн ч стандартад заасан хэмжээнээс маш бага байна. Үүний дотроос толуол болон ксилолын уламжлалууд нэлээдгүй илэрсэн нь түлшний гаралтай органик нэгдлүүдийн бохирдлоор бохирдох магадлалтай үр дүн ажиглагдаж байна (Хүснэгт 42).

Хүснэгт 42. Эх үүсвэрүүдийн НТГМ-ны хэмжээ

Эх үүсвэрүүд	Хлорформ	Бромдихлорметан	Дибромхлорметан	Бромформ	НТГМ
Б	0.13	0.3	1.37	1.98	3.79
В	0.39	0.39	1.8	2.8	5.38

Ундны усыг халдваргүйжүүлэхэд хлорформ, бромдихлорметан, дибромхлорметан болон бромформын нэгдлүүд үүсдэг бөгөөд нийлбэрээр нийт тригалогентметаны хэмжээгээр тооцдог. Судалгаанд хамрагдсан Б, В станцын усны үүсвэрүүдийн дүнд үүссэн хлорформ, бромдихлорметан, дибромхлорметан болон

бромформын нэгдлүүд үүсдэг бөгөөд нийлбэрээр нийт тригалогентметаны хэмжээг хүснэгт 42 болон график 24, 25-д үзүүлэв.




График 24. Б-станцын тригалогентметаны хэмжээ, мкг/л




График 25. В-станцын тригалогентметаны хэмжээ, мкг/л.

Хлор ашиглан ундны усыг халдваргүйжүүлэхэд бромт болон хлорт органик нэгдлүүд үүсэж байгаа хэдий ч нийт тригалогентметаны хэмжээ MNS болон бусад улс орнуудын мөрддөг стандарттай харьцуулахад маш бага байгаа нь галогент органик нэгдлийн эрсдэл бага байгаа нь сайн талтай юм.


Дүгнэлт: Хлор ашиглан халдваргүйжүүлэлт явуулахад усанд үүсэж болох органик нэгдлүүд буюу хлорформ, бромдихлорметан, дибромхлорметан, бромформ Б, В станцын усанд илэрч байгаа хэдий ч эдгээрийн нийлбэр тригалогентметаны хэмжээ нь MNS 0900:2018 болон бусад улс орны мөрддөг ундны усны стандартаас 10-25 дахин бага байна. Мөн үйлдвэрийн гаралтай органик бүрэлдэхүүний агуулгыг давтамжит хугацаагаар мониторинг хийж судлах нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Харин Б, В станцын эх үүсвэрийн зарим худгуудад толуол, стирен болон ксилолын уламжлалууд илэрсэн ч стандартад заасан хэмжээнээс маш бага байна. Үүний дотроос толуол болон ксилолын уламжлалууд нэлээдгүй илэрсэн нь түлшний гаралтай нэгдлүүдийн өвөрмөц хувирал зүй явагдсан нь тогтцын хувьд болон шилжилтийн улмаас сонирхолтой үр дүн гарсан нь органик бүрэлдэхүүний судалгааг цаашид ангилан үргэлжлүүлэх шаардлага байна.

III БҮЛЭГ. УЛААНБААТАР ХОТЫН ЗАРИМ ДҮҮРГИЙН ГЭР ХОРООЛЛЫН ИРГЭДИЙН УНД, АХУЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАДАГ ГҮНИЙ ХУДГУУДЫН ГИДРОХИМИЙН СУДАЛГАА

Нийслэл хотын хүн ам Туул голын дагуу байрласан ундны усны 240 орчим эх үүсвэрийн гүний худгуудаас ус дамжуулах станц, зөөврийн болон төвлөрсөн шугамд холбогдсон 600 гаруй ус түгээх байраас усаар хангагддаг. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Төвийн болон Гачууртын ус хангамжийн эх үүсвэрийн худгууд байрладаг байна. Сүүлийн жилүүдэд хотжилт, хүн амын өсөлт, төвлөрөл нэмэгдэхийн хэрээр хотын захын гэр хорооллууд өргөжин тэлж хүн ам, аж үйлдвэрийн унд, ахуй болон үйлдвэрлэлийн хэрэгцээний усны хэрэглээ эрс нэмэгдсээр байна [33]. Түүнчлэн хотын захын гэр хорооллын иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн гаргасан гүний болон энгийн уурхайн худгийн усыг унд, ахуйн хэрэгцээндээ ашиглаж байна. Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 2013 онд зохион байгуулж явуулсан өрөмдмөл, богино яндант, бетон хашлагатай уурхайн худаг, энгийн уурхайн (гар худаг) худгийн тооллогоор Багануур дүүрэгт 148, Багахангай дүүрэгт 33, Баянгол дүүрэгт 233, Баянзүрх дүүрэгт 1093, Налайх дүүрэгт 256, Сонгинохайрхан дүүрэгт 950, Сүхбаатар дүүрэгт 1309, Хан-Уул дүүрэгт 1089, Чингэлтэй дүүрэгт 220 тус тус тоологджээ [2]. Ундны ус нь хүн амын эрүүл мэндийг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Гэр хорооллуудын дунд гаргасан гүний худгуудын зарим нь гүехэн өрөмдсөн (хөрсний ус), эрүүл ахуйн бүсийн шаардлага хангаагүй мөн олон жил суурьшсан гэр хорооллын онцлогоос шалтгаалан бохирын нүхээр дамжин усны болон хөрсний бохирдлоос болж чанар найрлага өөрчлөгдөж эрүүл ахуйн шаардлага хангахгүйд хүрч байгааг олон судалгааны үр дүн харуулж байна [34]. Иймд ард иргэдийг төрөл бүрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, усны нөөцийг зүй зохистой хэрэглэх, иргэдийг ундны усны талаар бодит мэдээллээр хангагдах эрхийг хангах зэрэг шаардлага тулгарч байна. Иймээс энэ удаагийн судалгааны ажлаар Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн гэр хорооллын иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгийн усанд нарийвчилсан судалгаа хийж, усны чанарыг үнэлэн дүгнэлт өгөх зорилгоор энэхүү ажлыг хийж гүйцэтгэв.

Судалгааны объект

Энэ удаагийн судалгаанд Нийслэлийн Баянзүрх дүүргийн 28 хорооноос гэр хороолол зонхилсон 7 хороонд байрлах 55 гүний худаг, Баянгол дүүргийн 25 хорооноос 20, 23-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 18 гүний худаг, Сүхбаатар дүүргийн 11 хороонд байрлах хүн ам унд ахуйд өргөнөөр ашигладаг 62 гүний худаг нийт 135 гүний худгийн уснаас 2020, 2021 онд сорьц цуглуулж физик, химийн найрлага, бичил амь судлал, микроэлемент, цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг газар дээр нь болон лабораторид тодорхойлов. Судалгаанд хамрагдсан 3 дүүргийн гүний худгуудын байршлыг зураг 9-д үзүүлэв.



Зураг 9. Судалгаанд хамрагдсан 3 дүүргийн гүний худгуудын байршил

3.1. Баянзүрх дүүргийн гэр хорооллын иргэдийн унд, ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудын усны гидрохимийн судалгаа

Физик-химийн шинж чанар: Цахилгаан дамжуулах чанар (ЦДЧ) болон рН нь тухайн усны шинж чанарыг илтгэдэг чухал үзүүлэлтүүд юм. Судалгаанд хамрагдсан Баянзүрх дүүргийн гүний худгуудын цахилгаан дамжуулах чанар болон рН-ын хамаарлыг график 25-т үзүүлэв. Гүний усны рН нь олон төрлийн геохимийн тооцооллын чухал мэдээллийг өгдөг [35]. График 26-с харахад Баянзүрх дүүргийн гүний худгуудын усны рН 7.21-8.36 буюу саармагаас сул шүлтлэг орчинтой байгаа бөгөөд рН-ийн утгаараа MNS 0900:2018 болон ДЭМБ-аас [36] гаргасан дэлхийн улс орнуудын мөрдөж буй үндэсний стандартуудын шаардлагыг хангаж байна. Цахилгаан дамжуулах чанар (ЦДЧ) нь тухайн усны эрдэсжилттэй шууд хамааралтай байдаг. Судалгаа хийсэн гүний худгуудын усны цахилгаан дамжуулах чанар (ЦДЧ) 22.4-103.4 mS/m байна. Үүнээс үзэхэд 10-р хорооны 1 гүний худгийн ус Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 шаардлагыг хангахгүй байгаа хэдий Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гаргасан улс орнуудын мөрдөж буй ундны усны стандартын шаардлагыг хангаж байна (Хүснэгт 43). Судлаач L.A.Richards-н ангиллаар судалгаанд хамрагдсан гүний худгуудын ус нь цахилгаан дамжуулах чанараараа маш сайн буюу <25 mS/m болон зөвшөөрч болох буюу 75-200 mS/m гэсэн ангилалд хамаарагдаж байгааг тогтоов [37].




График 26. Цахилгаан дамжуулах чанар болон рН-ын хамаарал

Химийн найрлага: Судалгаанд хамрагдсан гүний худгуудын усны химийн шинжилгээний үр дүнг Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гаргасан улс орнуудын ундны усны стандарттай харьцуулан хүснэгт 43-д үзүүлэв. Химийн шинжилгээний үр дүнгээс харахад гүний худгуудын усны нийт хатуулаг 2.2-8.8 мг-экв/л буюу зөөлөн-зөөлөвтөр-хатуу, нийт эрдэжилт 210-1771 мг/л буюу цэнгэгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Баянзүрх дүүргийн 7 хороонд байрлах гүний худгуудын усанд үндсэн катион болох натри (Na^+) 2.9-376 мг/л, кальци (Ca^{2+}) 36-134 мг/л, магни (Mg^{2+}) 4.9-51.1 мг/л, кали (K^+) 0.3-3.2 мг/л байхад анионуудаас гидрокарбонат (HCO_3^-) 110-232 мг/л, хлор (Cl^-) 9.5-103 мг/л, сульфат (SO_4^{2-}) 2.5-866 мг/л, нитрит (NO_2^-) 0.01-1.17 мг/л, фтор (F^-) 0.04-1.5 мг/л тус тус агуулагдаж байгааг тодорхойлов. Судалгаанд хамрагдсан Баянзүрх дүүргийн гэр хорооллын гүний худгуудын усны физик, химийн шинжилгээний дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 3-3е-д үзүүлэв.

Хүснэгт 43. Гүний худгуудын усны физик, химийн найрлага, мг/л

№	Үзүүлэлтүүд	Бага	Их	Дундаж	MNS 0900:2018 (ЗДА)	ДЭМБ-гаргасан УОС	MNS 0900:2018 (ЗДА)-с хэтэрсэн худгууд
1	рН	7.21	8.36	7.79	6.5-8.5	6.5-8.5	-
2	ЕС, mS/m	22.4	103.4	62.9	100 mS/m	250 mS/m	10-р хорооны 1 худаг
3	ORP, mV	147	363	255	-	-	-
4	TDS, ppm	63	358	211	-	-	-
5	Нийт хатуулаг, мг-экв/л	2.2	8.8	5.5	7.0	-	10, 11, 23-р хорооны 3 худаг
6	ПИЧ	1.5	6.6	4.1	10	-	-
7	Натри, Na^+	2.9	375.6	189.3	200	200	10-р хорооны 1 худаг
8	Кали, K^+	0.3	3.2	1.75	-	-	-
9	Кальци, Ca^{2+}	36	134.1	85.1	100	150-300	10, 23-р хорооны 2 худаг
10	Магни, Mg^{2+}	4.9	51.1	28	30	<150-300	11-р хорооны 1 худаг
11	Аммони, NH_4^+	0.002	0.085	0.04	1.5	1.5	-
12	Төмөр, $\text{Fe}_{\text{нийт}}$	0.01	0.49	0.25	0.3	0.3	20-р хорооны 1 худаг
13	Карбонат, CO_3^{2-}	-	-	-	-	-	-

14	Гидрокарбонат, HCO_3^-	109.8	231.8	170.8	-	-	-
15	Хлор, Cl^-	9.5	102.8	56.2	350	250	-
16	Сульфат, SO_4^{2-}	2.5	865.8	434.2	500	250	10-р хорооны 1 худаг
17	Нитрит, NO_2^-	0.006	1.17	0.59	1.0	3.0	10-р хорооны 1 худаг
18	Нитрат, NO_3^-	0.8	134.7	67.8	50	50	10, 11, 12, 20, 23, 28-р хорооны 11 худаг
19	Фосфат, PO_4^{3-}	0.003	0.029	0.02	3.5	-	-
20	Фтор, F^-	0.04	1.5	0.87	0.7-1.5	1.5	0.7-с доош 48 худаг
21	Нийт эрдэжилт	210.3	1771	990.7	1000	-	10-р хорооны 1 худаг

Тайлбар: ЗДА-Зөвшөөрөгдөх дээд агууламж, УОС-Улс орнуудын стандарт

Хүснэгт 43-аас харахад Баянзүрх дүүргийн судалгаанд хамрагдсан гүний худгуудаас 10, 11, 23-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 3 гүний худгийн ус нийт хатуулгийн агуулгаараа Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна. Мөн судалгаанд хамрагдсан 55 гүний худгаас 10-р хорооны 1 гүний худгийн усанд Na^+ 375.6 мг/л, SO_4^{2-} 865.8 мг/л, 20-р хорооны 1 худгийн усанд $\text{Fe}_{\text{нийт}}$ 0.49 мг/л тус тус агуулагдаж байгаа нь Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон ДЭМБ-аас гаргасан улс орнуудын мөрдөж буй ундны усны стандартын шаардлагыг хангахгүй байна [25, 36]. Мөн тус дүүргийн судалгаанд хамрагдсан 21 гүний худгуудын усны F^- -ын агуулга стандартын доод утгаас доош агуулагдаж, 27 худгийн усанд огт илрээгүй байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна. Судалгаанд хамрагдсан гүний худгуудын усны кальци, магнийн ион болон нитратын ионы агуулгыг MNS стандарттай харьцуулан график 27, 28-д үзүүлэв.




График 27. БЗД-н гүний худгуудын кальци, магнийн ионы агуулга




График 28. БЗД-н гүний худгуудын нитрат ионы агуулга

Кальци, магнийн ион нь гадаргын болон гүний усанд хамгийн ихээр агуулагддаг элементүүдийн нэг юм [38]. График 26, 27-д үзүүлснээр тус дүүргийн 55 гүний худгаас 10, 23-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 2 гүний худаг Ca^{2+} ион, 11-р хорооны 1 худгийн ус Mg^{2+} ионы агуулгаараа Монгол улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна. Харин гүний худгуудын усны Ca^{2+} болон Mg^{2+} -н ионы агуулга ДЭМБ-аас гаргасан дэлхийн улс орнуудын мөрдөж буй ундны усны стандартын шаардлагаас бага агуулгатай байна [36]. Усан дахь Ca^{2+} болон Mg^{2+} нь силикатын чулуулаг болон доломитоос гаралтай байдаг [39]. Баянзүрх

дүүргийн 7 хороонд байрлах 55 гүний худгийн усанд нитрат (NO_3^-) 0.8-135 мг/л агуулагдаж байна. Үүнээс 10, 11, 12, 20, 23, 28-р хороонд байрлах 11 гүний худгийн усны NO_3^- 51-135 мг/л агуулагдаж байгаа нь MNS 0900:2018 болон ДЭМБ-аас гаргасан улс орнуудын мөрдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байгааг тодорхойлов. Нитратын бохирдол нь гүний усны бэрхшээлүүдийн нэг бөгөөд мал аж ахуйн байгууламж, органик бодис, бордооны ялзрал, бохир ус зэргээс үүсэлтэй байдаг [40, 41]. Судалгаанд хамрагдсан Баянзүрх дүүргийн 55 гүний худгаас 42 гүний худгийн ус нь химийн найрлагаараа Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон ДЭМБ-аас гаргасан улс орнуудын мөрдөж буй ундны усны стандартын шаардлагыг хангаж байна.




График 29. Судалгаанд хамрагдсан гүний худгуудын химийн найрлага

Баянзүрх дүүргийн гүний худгуудын усны химийн найрлагыг гурвалжингийн диаграммаар илэрхийлэн график 29-д үзүүлэв. Тус графикийн катионы гурвалжингаас харахад 10-р хорооны 1 худгийн усанд Na^+ , 11-р хорооны 1 худгийн усанд Mg^{2+} , бусад гүний худгуудын усанд Ca^{2+} ион давамгайлсан байна. Харин анионы гурвалжингаас харахад ихэнх худгийн усанд HCO_3^- ион давамгайлсан байхад 10-р хорооны 1 худгийн усанд SO_4^{2-} ион зонхилж байна. Үүнээс үзэхэд 10-р хорооны 1 худгийн ус $\text{SO}_4^{2-}-\text{Na}^+$ -ийн төрлийн, 11-р хорооны 1 худаг $\text{HCO}_3^- - \text{Mg}^{2+}$ -ийн төрлийн, бусад гүний худгуудын ус $\text{HCO}_3^- - \text{Ca}^{2+}$, Mg^{2+} -ийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна.

Ус, чулуулгийн харилцан үйлчлэл: Гиббсийн диаграмм нь газрын доорх усны гидрохимийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хянах механизм, тэдгээрийн хоорондын харилцан холбоог тодорхойлоход ашигладаг. Гиббсийн диаграммыг нийт ууссан давсны утгыг давамгайлсан катионуудын харьцаа $[\text{Na}^+ / (\text{Na}^+ + \text{Ca}^{2+})]$ болон анионууд $[\text{Cl}^- / (\text{Cl}^- + \text{HCO}_3^-)]$ -тай харьцуулж гаргадаг [42, 43]. Диаграммд дээрээс доош чиглэлд ууршилт, чулуулаг, хур тунадас гэсэн гурван механизмын мужид хуваадаг. Судалгаанд хамрагдсан гүний худгуудын химийн шинжилгээний дүнгээр Гиббсийн диаграмм байгуулан график 30-д

үзүүлэв. Уг диаграммаас харахад гүний хурднуудын ус нь чулуулаг давамгайлсан мужид оршиж байна. Энэ нь уст давхаргын чулуулаг, ус хоёрын хоорондын харилцан үйлчлэлийг илэрхийлэх бөгөөд ус чулуулгийн харилцан үйлчлэл нь газрын доорх усны химийн найрлагыг хянах гол хүчин зүйл болохыг харуулдаг [44]. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан гүний хурднуудын ус нь ус чулуулгийн харилцан үйлчлэлд орж усны бүтэц, химийн найрлага тухайн орчны геологийн тогтоц болон чулуулгаас хамаарч байгааг харуулж байна.




График 30. Гүний хурднуудын усны анион болон катионы Гиббсийн диаграмм

Микроэлемент: Баянзүрх дүүргийн гүний хурднуудын усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дэлгэрэнгүй дүнг хавсралт 3-3е–д үзүүлэв. Үүнээс MNS 0900:2018 стандартад тусгагдсан 18 үзүүлэлтүүдийг сонгон авч ДЭМБ-с гаргасан улс орнуудын мөрдөж буй ундны усны стандарттай харьцуулан хүснэгт 44-т харуулав. Шинжилгээний дүнгээс харахад 10-р хорооны 1 хурдны усанд бари, стронци, 11-р хорооны 2 хурдны усанд хүнцэл, манганы агуулга бусад хурднуудын уснаас өндөр байгаа хэдий ч Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон ДЭМБ-аас гаргасан улс орнуудын ундны усны стандарт шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 44. Гүний хурднуудын усны микроэлементийн агуулга, мкг/л

№	Үзүүлэлтүүд	Бага	Их	MNS 0900:2018 (ЗДА)	ДЭМБ-с гаргасан ОУС
1	Ag (Мөнгө)	<0.2		100	-
2	Al (Хөнгөнцагаан)	<10		500	-
3	As (Хүнцэл)	0.26	9.04	10	10
4	Ba (Бари)	<10	67	700	700
5	Be (Биндэр)	<0.1		0.2	-
6	Cd (Кадми)	<0.01	0.08	3	3
7	Cr (Хром)-нийт	<10		50	50
8	Cu (Зэс)	<5		2000	2000
9	Hg (Мөнгөн Ус)	<0.5	0.9	1	6
10	Mn (Манган)	<5	48	100	-
11	Mo (Молибден)	0.3	5.0	70	70
12	Ni (Никель)	0.9	9.2	20	70
13	Pb (Хар тугалга)	<0.5		10	10
14	Sb (Хэврэг цагаан)	<0.2	0.9	20	20
15	Se (Селен)	<0.2		40	40

16	Sr (Стронци)	170	1401	2000	-
17	U (Уран)	0.4	7.99	30	30
18	Zn (Цайр)	<5	73	5000	-

Тайлбар: ЗДА-Зөвшөөрөгдөх дээд агууламж, УОС-Улс орнуудын стандарт

Бичил амь судлалын үзүүлэлт: Усны чанарын биологийн аюулгүй байдлыг шалгах үндсэн арга нь бактериологийн буюу бичил амь судлалын үзүүлэлтийн хяналт байдаг [45]. Тус дүүргийн гүний худгуудын усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-тай харьцуулж хүснэгт 45-д үзүүлэв. Гүний худгуудаас 10, 12, 20, 23-р хорооны нийт 7 худгийн усны нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн байна. Харин 20, 23, 28-р хорооны 4 гүний худгийн усанд гэдэсний бүлгийн нийт нян илэрсэн мөн 23-р хорооны 1 худгийн усанд *E.coli*, халуунд тэсвэртэй *E.coli* илэрсэн байгааг тодорхойлов. Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан гүний худгуудаас 10 худаг бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна. Эдгээр худгуудын усыг унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй тул эрүүл ахуйн бүс тогтоож, ариутгал халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин бичил амь судлалын шинжилгээнд хамруулж хэрэглэх шаардлагатай.

Хүснэгт 45. Гүний худгуудын усны бичил амь судлалын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Бага	Их	MNS 0900:2018 (ЗДА)	MNS 0900:2018 (ЗДА)-с хэтэрсэн худгууд
1	Нийт нянгийн тоо	тоо/1мл	0	526	<100	10, 12, 20, 23-р хорооны 7 худаг
2	Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	тоо/100мл	0	400	-	20, 23, 28-р хорооны 4 худаг
3	<i>E.coli</i>		-	+	-	23-р хорооны 1 худаг
4	Халуунд тэсвэртэй <i>E.coli</i>		-	+	-	
5	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян (<i>Salmonella/ Shigella</i>)	тоо/25мл	-	-	-/-	-/-

Тайлбар: ЗДА-Зөвшөөрөгдөх дээд агууламж

Цацрагийн аюулгүйн үзүүлэлт: Радон (^{222}Rn) нь байгалийн гаралтай цорын ганц цацраг идэвхт хий бөгөөд уран агуулсан хөрс, чулуулаг, усан дахь ураны задралаас үүсдэг. Радон нь радигийн задралаас үүсдэг ба радон, ради нь уран (^{238}U)-ы задралын бүтээгдэхүүн юм. Мөн гүний усан дахь радоны хэмжээ гадаргын усан дахь радоны хэмжээнээс харьцангуй өндөр байдаг [27]. Ундны усанд цацрагийн эрүүл ахуйн үүднээс радоны хэмжээг хянаж байх шаардлагатай. Тиймээс гүний худгуудын усанд ^{222}Rn болон түүний задралын бүтээгдэхүүн болох ^{226}Ra , ^{238}U , ^{214}Pb , ^{214}Bi гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон үр дүнгээс радоны агуулгыг график 31-д үзүүлэв. Баянзүрх дүүргийн судалгаанд хамрагдсан 55 гүний худгаас 20, 23-р хорооны 3 худгийн усанд радон (^{222}Rn) 102-110 Бк/л, 28-р хорооны 7 гүний худгийн усанд радон (^{222}Rn) 105-135 Бк/л агуулагдаж байна. Үүнээс үзэхэд 10 худаг цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна.




График 31. Гүний худгуудын усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт

Судлаач Н.Норов ба бусад судлаачид Улаанбаатар хотын унд ахуйн хэрэгцээний ба гүний худгийн усны дээжид хийсэн судалгаагаар ради, радоны хооронд цацраг идэвхийн тэнцвэр тогтоогүй байгааг илрүүлсэн байна [27]. Энэ нь ^{222}Rn усанд агуулагдах Ra-аас үүсээгүй, харин орчны геологийн тогтоц, чулуулгаас хий байдалтай үүсэх ^{222}Rn –ыг ус өөртөө уусган авдаг гэж үзэж байна.

Дүгнэлт: Баянзүрх дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгийн ус нь саармагаас сул шүлтлэг орчинтой, зөөлнөөс хатуу, цэнгэгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Нийт 55 гүний худгийн ус судалгаанд хамрагдсанаас 25 худгийн ус Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гаргасан улс орнуудын мөрддөг ундны усны стандарт шаардлагыг хангахгүй усыг унд ахуйдаа хэрэглэж байгааг тогтоов. Хатуулаг ихтэй усыг өдөр тутам унд ахуйд хэрэглэхэд эрүүл мэндэд тохиромжгүй учир нүүрсэн болон катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглах мөн бичил амь судлалын үзүүлэлтээрээ стандарт шаардлага хангахгүй байгаа худагт ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин бичил амь судлалын шинжилгээнд хамруулж унданд хэрэглэх шаардлагатай. Баянзүрх дүүргийн ундны усны зориулалтаар ашиглаж буй 30 гүний худгийн ус нь ерөнхий химийн найрлага, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөж буй MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна. Судалгаанд хамрагдсан гүний худгуудын ус нь ус, чулуулгийн харилцан үйлчлэлд орж усны бүтэц, химийн найрлага тухайн орчны геологийн тогтоц болон чулуулгаас хамаарч байгааг тодорхойллоо.

3.2. Баянгол дүүргийн гэр хорооллын иргэдийн унд, ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудын усны гидрохимийн судалгаа

Судалгаанд хамрагдсан Баянгол дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн шинжилгээний дүнг график 32-т үзүүлэв. Тус графикаас харахад физик-химийн үзүүлэлтээрээ - 94.4%, ерөнхий химийн үзүүлэлтээрээ - 66.6%, микроэлементүүдийн агуулгаараа – 83.3%, бичил амь судлалын үзүүлэлтээрээ – 16.7%, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ – 100% Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангаж байна.




График 32. Баянгол дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн судалгаа

Физик-химийн шинж чанар: Улаанбаатар хотын Баянгол дүүргийн гэр хороолол зонхилсон 20, 22, 23-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 18 гүний хурдгийн усны физик-химийн шинжилгээний дүнг хүснэгт 46-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад хурдгуудын ус өнгө, үнэргүй (pH 6.57-7.61) буюу саармаг орчинтой, цахилгаан дамжуулах чанар (EC) 17.8-136.1 mS/m, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 178-188 mV, нийт ууссан давс буюу (TDS) 87-680 ppm тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд 23-р хороонд байрлах "Амаяа-Аяама" ХХК-н хурдгийн ус цахилгаан дамжуулах чанараараа "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 46. Гүний хурдгуудын усны физик-химийн үзүүлэлт

№	Хороо	Сорьц авсан газрын нэр	pH	EC, mS/m	ORP, mV	TDS, ppm
1	20	"Alliance tech" ХХК худаг	7.03	38.7	178	193
2		"Мон-Инган" ХХК худаг	6.89	39.9	182	199
3		Ц.Батбаярын худаг	6.8	61.7	183	308
4		"Тулга төхөөрөмж" ХХК худаг	6.91	48.5	182	242
5		Ц.Хишигжаргалын худаг	6.74	76.1	186	380
6		Мон-Ар ХХК худаг	6.89	64.8	183	324
7		Ишган трейд худаг	6.94	70.4	181	352
8		Оргил мөнх трейд ХХК худаг	7.04	60.1	170	300
9		"Хос бэрх" ХХК-н худаг	6.57	17.8	175	87

10		М.Цэцэгчулууны худаг	6.85	34.3	180	170
11		Уран дрилинг ХХК-ны худаг	6.79	32.2	188	150
12		Евровүүд ХХК-ийн худаг	6.86	31.3	176	156
13		Цамхагт Асар ХХК-ны худаг	6.81	27.5	183	136
14		Алейск Импекс ХХК-ны худаг	6.91	23.6	183	118
15	22	Т.Эрдэнэ-Оргилын худаг	7.6	78.8	168	394
16	23	"Амаяа-Аяама" ХХК худаг	7.22	136.1	182	680
17		Б.Бямбасүрэнгийн худаг	7.61	33.5	177	167
18		Monfood lanel ХХК худаг	7.23	66.3	175	331
MNS 0900:2018 (ЗДА)			6.5-8.5	100	-	-

Химийн найрлага: Тус дүүргийн судалгаанд хамрагдсан гэр хорооллын гүний худгуудын усны химийн шинжилгээний дүнгээс харахад нийт хатуулаг 2.0-16.6 мг-экв/л буюу зөөлнөөс маш хатуу, нийт эрдэсжилт 173.7-1237 мг/л буюу нэн цэнгэгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Гүний худгуудын усанд үндсэн катионуудаас кальцийн ион давамгайлж (Ca^{2+}) 36-230.2 мг/л, магни (Mg^{2+}) 7.3-62.0 мг/л, натри (Na^{+}) 2.2-89.4 мг/л харин анионуудаас гидрокарбонатын ион давамгайлж (HCO_3^{-}) 61-427 мг/л, сульфат (SO_4^{2-}) 34.6-289.7 мг/л, хлор (Cl^{-}) 12.6-184.4 мг/л, нитрит (NO_2^{-}) 0-0.7 мг/л, нитрат (NO_3^{-}) 2-134.6 мг/л, фтор (F^{-}) 0-0.6 мг/л тус тус агуулагдаж байна (Хүснэгт 47, 48).

Хүснэгт 47. Баянгол дүүргийн гүний худгуудын усны катионы найрлага, мг/л

Хо-роо	Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг мг-экв/л	Na^{+}	K^{+}	Ca^{2+}	Mg^{2+}	NH_4^{+}	$F_{\text{нийт}}$
20	"Alliance tech" ХХК худаг	2.14	3.6	26.6	3.0	56.1	9.7	0.1	-
	"Мон-Инган" ХХК худаг	3.38	3.2	40.3	1.8	50.1	8.5	-	-
	Ц.Батбаярын худаг	2.35	5.7	45.4	4.0	88.1	15.8	0.1	-
	"Тулга төхөөрөмж" ХХК худаг	3.54	5.6	12.9	2.6	94.1	10.9	0.1	-
	Ц.Хишигжаргалын худаг	3.05	6.5	82.6	5.0	100	18.2	0.1	-
	Мон-Ар ХХК худаг	2.84	5.5	89.4	3.7	96.1	8.5	0.1	-
	Ишган трейд худаг	4.04	6.3	55.2	4.3	92.1	20.7	0.1	-
	Оргил мөнх трейд ХХК худаг	2.97	5.6	54.4	3.7	90.1	13.4	0.2	-
	"Хос бэрх" ХХК-н худаг	3.12	2.0	10.1	1.1	28.0	7.3	0.0	-
	М.Цэцэгчулууны худаг	2.00	3.1	10.2	2.6	50.1	7.3	0.0	-
	Уран дрилинг ХХК-ны худаг	4.24	3.0	23.7	2.2	52.1	4.9	0.0	-
	Евровүүд ХХК-ийн худаг	3.28	3.0	19.1	2.4	48.0	7.3	0.0	-
	Цамхагт Асар ХХК-ны худаг	2.88	2.9	6.0	2.1	40.0	10.9	0.0	-
	Алейск Импекс ХХК-ны худаг	1.84	2.6	2.2	1.7	36.0	9.7	0.0	-
22	Т.Эрдэнэ-Оргилын худаг	2.9	8	44.3	2	100.1	36.5	0.16	
23	"Амаяа-Аяама" ХХК худаг	3.05	16.6	37.1	2.6	230.2	62.0	0.2	-
	Б.Бямбасүрэнгийн худаг	2.47	3.8	38.2	1.6	46.0	18.2	0.1	-
	Monfood lanel ХХК худаг	3.05	7.4	19.2	1.3	92.1	34.0	0.2	-
MNS 0900:2018 (ЗДА)		10	7.0	200	100	30	1.5	0.3	

Хүснэгт 48. Баянгол дүүргийн гүний худгуудын усны анионы найрлага, мг/л

Хо-роо	Сорьц авсан газрын нэр	CO_3^{2-}	HCO_3^{-}	Cl^{-}	SO_4^{2-}	NO_2^{-}	NO_3^{-}	F^{-}	Нийт эрдэс-жилт
20	"Alliance tech" ХХК худаг	-	170.8	31.9	38.7	0.01	20.7	-	357.6
	"Мон-Инган" ХХК худаг	-	128.1	74.5	34.6	-	5.0	-	342.9
	Ц.Батбаярын худаг	-	225.7	67.4	64.2	-	52.4	-	563.0

	"Тулга төхөөрөмж" ХХК худаг	-	79.3	24.8	194.2	-	12.0	-	431.1
	Ц.Хишигжаргалын худаг	-	176.9	95.7	130.0	0.7	118.2	-	727.6
	Мон-Ар ХХК худаг	-	213.5	78.0	143.2	0.1	50.0	-	682.5
	Ишган трейд худаг	-	213.5	70.9	61.7	-	125.9	-	644.4
	Оргил мөнх трейд ХХК худаг	-	219.6	67.4	74.1	-	63.8	0.3	586.6
	"Хос бэрх" ХХК-н худаг	-	61.0	12.6	53.5	-	-	0.1	173.7
	М.Цэцэгчулууны худаг	-	79.3	31.6	68.3	-	-	0.3	249.4
	Уран дрининг ХХК-ны худаг	-	97.6	28.4	51.0	-	38.8	0.5	298.6
	Евровүүд ХХК-ийн худаг	-	79.3	25.2	71.6	-	24.2	0.2	277.2
	Цамхагт Асар ХХК-ны худаг	-	91.5	15.8	60.1	-	1.1	0.6	227.5
	Алейск Импекс ХХК-ны худаг	-	79.3	15.8	47.7	-	0.1	0.3	192.6
22	Т.Эрдэнэ-Оргилын худаг	-	317.2	74.5	24.7	-	134.6	-	599.4
23	"Амаяа-Аяама" ХХК худаг	-	427.0	184.4	289.7	-	3.7	0.1	1237
	Б.Бямбасүрэнгийн худаг	-	274.5	14.2	27.2	-	2.9	0.3	423.0
	Monfood lanel ХХК худаг	-	372.1	44.2	37.0	0.-1	10.0	0.1	610.3
MNS 0900:2018 (ЗДА)		-	-	350	500	1.0	50	0.5-1.7	1000

Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан гүний худгуудаас 23-р хорооны 2 худаг нийт хатуулаг, магни, 23-р хорооны 2 худаг кальци, 20, 22, 23-р хорооны 6 худаг нитратын ионы агуулгаараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Баянгол дүүргийн гүний худгуудын усны химийн найрлагыг гурвалжингийн диаграммаар график 33-т үзүүлэв. Тус графикийн катионы гурвалжингаас харахад гүний худгуудын усанд Ca^{2+} ион давамгайлсан байна.




График 33. Судалгаанд хамрагдсан гүний худгуудын химийн найрлага

Харин анионы гурвалжингаас харахад 22-р хорооны 1 худаг, 23-р хорооны 2 худгийн усанд HCO_3^- -н ион давамгайлсан байхад 20-р хорооны худгууд, 23-р хорооны 1 худгийн усанд HCO_3^- , SO_4^{2-} ион зонхилж байна. Үүнээс үзэхэд 22-р хорооны 1, 23-р хорооны 2 худгийн ус $\text{HCO}_3^- - \text{Ca}^{2+}$, Mg^{2+} , бусад худгийн ус $\text{HCO}_3^- - \text{SO}_4^{2-} - \text{Ca}^{2+}$, Mg^{2+} төрлийн холимог найрлагатай усны ангилалд хамаарагдаж байна.

Микроэлемент: Баянгол дүүргийн 20, 22, 23-р хорооны нийт 18 гүний худгуудын усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дэлгэрэнгүй дүнг хавсралт 4-4а-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад 20-р хорооны иргэн Ц.Хишигжаргалын худгийн усанд манган (Mn 160 мкг/л), 22-р хорооны иргэн Т. Эрдэнэ-Очир, 23-р хорооны “Амая-Аяама” ХХК-н худгийн усанд стронци (Sr 2247-2588 мкг/л) агуулагдаж байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй байна.

Бичил амь судлалын үзүүлэлт: Тус дүүргийн гүний худгуудын усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 49-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад 20, 23-р хорооны 4 худгийн усны нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн, 14 худгийн усанд гэдэсний бүлгийн нян илэрсэн байна. Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан гүний худгуудаас 15 худаг бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байгааг тодорхойлов. Эдгээр худгуудын усыг унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй тул эрүүл ахуйн бүс тогтоож, ариутгал халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин шинжилгээнд хамруулж хэрэглэх шаардлагатай.

Хүснэгт 49. Гүний худгуудын усны бичил амь судлалын үзүүлэлтүүд

Хо-роо	Сорьц авсан газрын нэр	Нийт нянгийн тоо	Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	<i>E. coli</i>	Халуунд тэсвэртэй <i>E. coli</i>	(<i>Salmonella</i> / <i>Shigella</i>)
20	"Alliance tech" ХХК худаг	24	22	-	-	-
	"Мон-Инган" ХХК худаг	35	24	-	-	-/-
	Ц.Батбаярын худаг	3	0	-	-	-/-
	"Тулга төхөөрөмж" ХХК худаг	104	49	-	-	-/-
	Ц.Хишигжаргалын худаг	7	7	-	-	-/-
	Мон-Ар ХХК худаг	111	70	-	-	-/-
	Ишган трейд худаг	132	71	-	-	-/-
	Оргил мөнх трейд ХХК худаг	67	14	-	-	-/-
	"Хос бэрх" ХХК-н худаг	44	26	-	-	-/-
	М.Цэцэгчулууны худаг	19	10	-	-	-/-
	Уран дрилинг ХХК-ны худаг	22	15	-	-	-/-
	Евровүүд ХХК-ийн худаг	62	14	-	-	-/-
	Цамхагт Асар ХХК-ны худаг	19	10	-	-	-/-
	Алейск Импекс ХХК-ны худаг	89	71	-	-	-/-
22	Т.Эрдэнэ-Оргилын худаг	0	0	-	-	-/-
23	"Амая-Аяама" ХХК худаг	0	0	-	-	-/-
	Б.Бямбасүрэнгийн худаг	252	0	-	-	-/-
	Monfood lanel ХХК худаг	20	14	-	-	-/-

Цацрагийн аюулгүйн үзүүлэлт: Судалгаанд хамрагдсан гүний худгуудын усанд ^{222}Rn болон түүний задралын бүтээгдэхүүн болох ^{226}Ra , ^{238}U , ^{214}Pb , ^{214}Bi гэсэн

үзүүлэлтүүдийг тодорхойлсон дүнг хүснэгт 50-д үзүүлэв. Шинжилгээний үр дүнгээс харахад тус дүүргийн гүний худгийн ус цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 50. Гүний худгуудын усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт, Бк/л

Хороо	Сорьц авсан газрын нэр	Изотопын эзлэхүүний идэвх				
		²¹⁴ Pb	²¹⁴ Bi	²²² Rn	²²⁶ Ra	²³⁸ U
20	"Alliance tech" ХХК худаг	82	105	94	<0.4	<0.4
	"Мон-Инган" ХХК худаг	45	58	52	<0.4	<0.4
	Ц.Батбаярын худаг	48	63	56	<0.4	<0.4
	"Тулга төхөөрөмж" ХХК худаг	76	82	79	<0.4	<0.4
	Ц.Хишигжаргалын худаг	80	89	84	<0.4	<0.4
	Мон-Ар ХХК худаг	66	78	72	<0.4	<0.4
	Ишган трейд худаг	16	21	18	<0.4	<0.4
	Оргил мөнх трейд ХХК худаг	18	23	21	<0.4	<0.4
	"Хос бэрх" ХХК худаг	40	41	41	<0.4	<0.4
	М.Цэцэгчулууны худаг	21	21	21	<0.4	<0.4
	Уран дрининг ХХК худаг	27	30	28	<0.4	<0.4
	Евровүүд ХХК худаг	28	31	30	<0.4	<0.4
	Цамхагт Асар ХХК худаг	50	64	57	<0.4	<0.4
Алейск Испекс ХХК худаг	31	35	33	<0.4	<0.4	
22	Т.Эрдэнэ-Оргилын худаг	60	74	67	<0.4	<0.4
23	Амаяа-Аяама ХХК худаг	36	46	41	<0.4	<0.4
	Б.Бямбасүрэнгийн худаг	68	84	76	<0.4	<0.4
	Monfood Ianel ХХК худаг	11	12	12	<0.4	<0.4
Илрүүлэх доод хязгаар (1л эзлэхүүнтэй, 1 цаг хэмжих үед)		0.3	0.5	0.4	0.4	0.4
MNS 0900:2018 (ЗДА)		-	-	100	0.5	0.37 (0.03мг/л)

Дүгнэлт: Баянгол дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгуудын ус саармаг орчинтой, зөөлнөөс маш хатуу, нэн цэнгэгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Мөн судалгаанд хамрагдсан гүний худгуудаас 20-р хорооны 1 худаг цахилгаан дамжуулах чанар, нийт хатуулгаараа, 23-р хорооны 2 худаг кальцийн ион, 20, 22, 23-р хорооны 3 худаг магнийн ион, 20, 22, 23-р хорооны 6 худаг нитрат ионы агуулгаараа, 15 худаг бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018–н шаардлагыг хангахгүй байгааг тогтоов.

3.3. Сүхбаатар дүүргийн гэр хорооллын иргэдийн унд, ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудын усны гидрохимийн судалгаа

Судалгаанд хамрагдсан Сүхбаатар дүүргийн гүний худгуудын усны гидрохимийн шинжилгээний дүнг график 34-т үзүүлэв. Тус графикаас харахад ерөнхий химийн үзүүлэлтээрээ - 85%, бичил амь судлалын үзүүлэлтээрээ – 73%, микроэлементүүдийн агуулгаараа – 100%, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ – 100% тус тус Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна.




График 34. Сүхбаатар дүүргийн гүний худгуудын гидрохимийн судалгаа

Тус дүүргийн гүний худгуудын усны химийн шинжилгээний үр дүнг Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-тай харьцуулан хүснэгт 51-д үзүүлэв. Химийн шинжилгээний дүнгээс харахад гүний худгуудын усны нийт хатуулаг 1-13.2 мг-экв/л буюу зөөлөн-зөөлөвтөр-маш хатуу, нийт эрдэсжилт 185-1256 мг/л буюу нэн цэнгэгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Сүхбаатар дүүргийн 11 хороонд байрлах гүний худгуудын усанд үндсэн катион болох натри (Na^+) 2.9-46.4 мг/л, кальци (Ca^{2+}) 28-212.2 мг/л, магни (Mg^{2+}) 3.6-68.1 мг/л, кали (K^+) 0.3-7.4 мг/л байхад анионуудаас гидрокарбонат (HCO_3^-) 54.9-329.4 мг/л, хлор (Cl^-) 7.1-163.1 мг/л, сульфат (SO_4^{2-}) 9.9-369.5 мг/л, нитрит (NO_2^-) 0-0.24 мг/л, фтор (F^-) 0-0.85 мг/л тус тус агуулагдаж байгааг тодорхойлов. Сүхбаатар дүүргийн гэр хорооллын гүний худгуудын усны физик, химийн шинжилгээний дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 5-5е-д үзүүлэв.

Хүснэгт 51. Гүний худгуудын усны химийн найрлага, мг/л

№	Үзүүлэлтүүд	Бага	Их	Дундаж	MNS 0900:2018 (ЗДА)	MNS 0900:2018 (ЗДА)-с хэтэрсэн худгууд
1	pH	6.09	7.84	6.97	6.5-8.5	-
2	EC, mS/m	8.1	145.2	76.7	100 mS/m	12, 14-р хорооны 2 худгаг
3	ORP, mV	102	288	195	-	-
4	TDS, ppm	30	514	272	-	-

5	Нийт хатуулаг, мг-экв/л	1.0	13.2	7.1	7.0	9, 12, 14-р хорооны 3 худаг
6	ПИЧ	1.9	5.9	3.9	10	-
7	Натри, Na ⁺	2.9	46.4	24.7	200	-
8	Кали, K ⁺	0.3	7.4	3.9	-	-
9	Кальци, Ca ²⁺	28	212.2	120.1	100	12, 14, 16-р хорооны 3 худаг
10	Магни, Mg ²⁺	3.6	68.1	35.9	30	9, 12-р хорооны 2 худаг
11	Аммони, NH ₄ ⁻	0	0.14	0.07	1.5	-
12	Төмөр, Fe _{нийт}	0	0.05	0.025	0.3	-
13	Карбонат, CO ₃ ²⁻	-			-	-
14	Гидрокарбонат, HCO ₃ ⁻	54.9	329.4	192.2	-	-
15	Хлор, Cl ⁻	7.1	163.1	168.3	350	-
16	Сульфат, SO ₄ ²⁻	9.9	369.5	189.7	500	-
17	Нитрит, NO ₂ ⁻	0	0.24	0.12	1.0	-
18	Нитрат, NO ₃ ⁻	0	143.8	71.9	50	12, 14, 16, 18, 20-р хорооны 8 худаг
19	Фосфат, PO ₄ ³⁻	0	0.11	0.006	3.5	-
20	Фтор, F ⁻	0	0.85	0.43	0.7-1.5	11 хорооны 59 худаг/доод утгад хүрээгүй/
21	Нийт эрдэсжилт	185	1256	720.5	1000	12-р хорооны 1 худаг

Тайлбар: ЗДА-Зөвшөөрөгдөх дээд агууламж,

Уг гүний худгуудын усны нийт хатуулаг, кальци, магнийн ионы агуулгыг MNS стандарттай харьцуулан график 35, 36-д үзүүлэв. Тус графикаас харахад Сүхбаатар дүүргийн 11 хороонд байрлах 62 гүний худгаас 9, 12, 14-р хороонд байрлах 3 гүний худаг нийт хатуулгаараа, 12, 14, 16-р хорооны 3 гүний худаг Ca²⁺ ионы агуулгаараа, 9, 12-р хороонд байрлах 2 гүний худаг Mg²⁺ ионы агуулгаараа тус тус Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна.




График 35. СБД-н гүний худгуудын усны нийт хатуулаг




График 36. СБД-н гүний худгуудын усны кальци, магнийн ионы агуулга

Сүхбаатар дүүргийн 11 хороонд байрлах 62 гүний худгаас 9, 14, 16, 18-р хороонд байрлах 7 гүний худгийн усны нитрат (NO₃⁻) 54-144 мг/л агуулагдаж байгаа нь MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна (График 37).




График 37. Стандарт шаардлага хангаагүй гүний худагуудын нитрат ионы агуулга

Мөн тус дүүргийн нутаг дэвсгэрт орших 62 гүний худгийн усны химийн найрлагыг гурвалжингийн диаграммаар илэрхийлэн график 38-д үзүүлэв. Тус графикийн катионы гурвалжингаас харахад худгийн усанд Ca^{2+} , Mg^{2+} -ийн ион давамгайлсан байна. Харин анионы гурвалжингаас харахад ихэнх худгийн усанд HCO_3^- ион давамгайлсан байхад 12-р хорооны 1 худгийн усанд SO_4^{2-} -ын ион, 14, 13, 20-р хорооны 4 худгийн усанд HCO_3^- , SO_4^{2-} -ын зонхилж байна. Үүнээс үзэхэд 12 хорооны 1 гүний худгийн ус SO_4^{2-} - Ca^{2+} , Mg^{2+} -ийн төрлийн, 13, 14, 20-р хороонд байрлах 4 худгийн ус HCO_3^- , SO_4^{2-} - Ca^{2+} , Mg^{2+} -ийн төрлийн бусад хорооны гүний худгууд HCO_3^- - Ca^{2+} , Mg^{2+} -ийн төрлийн усны ангилалд тус тус хамаарагдаж байна.




График 38. Судалгаанд хамрагдсан гүний худагуудын химийн найрлага

Микроэлемент: Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт орших 62 гүний худгуудын усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хавсралт 5-5е-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад тус дүүргийн гүний худгуудын ус бичил элементүүдийн агуулгаараа Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангаж байна.

Бичил амь судлалын үзүүлэлт: Судалгаанд хамрагдсан гүний худгуудын усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-тай харьцуулж хүснэгт 52-т үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад гүний худгуудаас 14, 16, 17, 18, 20-р хорооны 14 худгийн усны нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн байна. Харин 14, 16, 17, 18, 20-р хорооны 8 худгийн усанд гэдэсний бүлгийн нян илэрсэн байгааг тодорхойлов. Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан гүний худгуудаас 17 худаг бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 52. Гүний худгуудын усны бичил амь судлалын үзүүлэлтүүд

№	Хороо	Сорьц авсан газрын нэр	Нийт нянгийн тоо	Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	<i>E.coli</i>	Халуунд тэсвэртэй <i>E.coli</i>	<i>Salmonella/Shigella</i>
1	XIV- хороо	Б.Ганзоригийн худаг	100<	53	-	-	-/-
2	XVI - хороо	171-р цэцэрлэг	40	5	-	-	-/-
3		Од дэлгүүр	82	15	-	-	-/-
4	XVII - хороо	А.Энхтөрийн худаг	732	0	-	-	-/-
5		Гүний худаг	100<	5	-	-	-/-
6		Авто баазын худаг	100<	0	-	-	-/-
7	XVIII - хороо	Ж.Даваажавын худаг	374	4	-	-	-/-
8		Д.Ганбаатарын худаг	302	0	-	-	-/-
9		Гүнжийн 43-565 тоот худаг	190	0	-	-	-/-
10		52-р худаг	134	0	-	-	-/-
11		Г.Намжирмаагийн худаг	257	0	-	-	-/-
12		Л.Ганпүрэвийн худаг	100<	14	-	-	-/-
13		И.Алтантуяагийн худаг	128	0	-	-	-/-
14	XX - хороо	Сэлх 18-1870 тоот	100<	7	-	-	-/-
15		Н.Мөнхчулууны худаг	82	14	-	-	-/-
16		217-р цэцэрлэгийн худаг	100<	0	-	-	-/-
17		Номун амралт	100<	0	-	-	-/-
MNS 0900:2018 (ЗДА)			<100	0	-	-	-/-

Цацрагийн аюулгүйн үзүүлэлт: Тус дүүргийн гүний худгуудын усанд ^{222}Rn болон түүний задралын бүтээгдэхүүн болох ^{226}Ra , ^{238}U , ^{214}Pb , ^{214}Bi гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон үр дүнг хавсралт 5-5д-д үзүүлэв. Шинжилгээний үр дүнгээс харахад гүний худгийн ус цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангаж байна.

Дүгнэлт: Сүхбаатар дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй нийт 62 гүний худгийн усны дээж судалгаанд хамрагдсанаас 21 худаг нийт хатуулаг, кальци, магни, нитрат ионы агуулга болон бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол

улсад мөрдөж буй MNS 0900:2018 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн байгааг тогтоов. Хатуулаг ихтэй усыг өдөр тутам унд ахуйд хэрэглэхэд эрүүл мэндэд тохиромжгүй учир нүүрсэн болон катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглах мөн бичил амь судлалын үзүүлэлтээрээ стандарт шаардлага хангахгүй байгаа худагт ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин шинжилгээнд хамруулж унданд хэрэглэх шаардлагатай байгааг тодорхойлов.

Зөвлөмж:

Судалгаагаар 3 дүүргийн 44 худгийн усны нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн мөн гэдэсний бүлгийн нийт нян илэрсэн нь Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тохирохгүй байна. Тиймээс унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд буцалгаж хэрэглэх шаардлагатай. Мөн тус худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин бичил амь судлалын шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Түүнчлэн Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.1-д заасны дагуу гүний худгаас 50 метр зайд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, бохирдол үүсэхээс хамгаалах хэрэгтэй.

Мөн судалгаанд хамрагдсан 3 дүүргийн гүний худгуудаас нийт хатуулаг, кальци, магни ионы агуулгаараа Монгол улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байгаа худгийн усыг унд ахуйд удаан хугацаанд хэрэглэхэд тохиромжгүй учир катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглахыг зөвлөж байна.

Гэр хорооллын иргэдийн унд ахуйд хэрэглэдэг гүний худгуудаас нитратын (NO_3^-) ионы агуулгаараа Монгол улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байгаа худгуудын нитратыг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх нь зүйтэй. Нитратыг уснаас ион солилцоо, урвуу осмос, электродиализ, мембран, биологийн арга зэргийг ашиглан бууруулж болдог. Эдгээр аргуудаас ион солилцоо болон мембран процесс нь жижиг усан хангамжийн хувьд илүү тохиромжтой байдаг. Ион солилцооны процесст нитрат ионыг хлорид эсвэл бикарбонат болгон солилцдог шүлтлэг анион солилцооны давирхай агуулсан шүүлтүүрээр нэвтрүүлэн усан дахь нитратыг цэвэрлэдэг.

IV БҮЛЭГ. ГАДАРГЫН УСНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА


4.1. Туул голын усны чанарын судалгаа

Ус бол биологийн бүх л нэгдлүүдийн салшгүй нэгэн хэсэг бөгөөд амьд байгалийн оршин тогтнох үндсэн нөхцөлийн нэг юм. Үүний зэрэгцээ хамгийн үнэ цэнэтэй ашигт малтмал бөгөөд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын үйл ажиллагаанд ямар нэг хэмжээгээр оролцож, үр шимээ хүртээж байдаг стратегийн чухал түүхий эд билээ. Иймээс усны нөөцийг хамгаалах, цэвэр байлгах, нэмэгдүүлэх, хойч үедээ хадгалан үлдээх асуудал нийгэм, эдийн засгийн бүх салбарыг хамарч өргөн хүрээгээр тавигдах болсон [46]. Туул гол нь Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт Хан Хэнтий нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2289.2 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс эх авсан Номин, Нэргүй хэмээх 2 голын уулзвараас Туул гол гэдэг нэрийг авч 717 км урт урссаар Сэлэнгэ аймгийн нутагт орших Орхон голд цутгадаг [47]. Туул гол нь байгалийн бүс, бүслүүрийн хувьд эхэн хэсэгтээ уулын тайгын бүс, ойт хээрийн бүсийг дамнан урсах ба Улаанбаатар хотоос доош сав газрын 80 гаруй хувь нь хээрийн бүсээр урсдаг. Гол нь эхэн хэсэгтээ эгц хад, хясаа болон ой мод элбэгтэй, уулсын 1-3 км өргөн хөндийтэй ба цаашид голын хөндий өргөссөөр Улаанбаатар хот орчимд 8-10 км болно [48]. Сүүлийн жилүүдэд хүний болон байгалийн бусад хүчин зүйлээс үүдэлтэй голын усны чанарын доройтол нь хүний эрүүл мэнд, экосистемд олон замаар сөрөг нөлөө үзүүлж, усан хангамжийн хүртээмжийг бууруулж, усыг төрөл бүрийн хэрэгцээнд ашиглах боломжгүй болгож байна [49]. Улаанбаатар хотын ус хангамжийг бүхэлд нь Туул голын уст давхаргаас хангадаг бөгөөд хүн амын хурдацтай өсөлт, хотжилт нэмэгдэж байгаа нь гадаргын болон газрын доорх усны чанар, орчны нөхцөл зэрэгт ихээхэн хэмжээний өөрчлөлтийг бий болгож байна. 1950-1970-аад оны үед Туул голын эрдэсжилт урсгалынхаа дагууд 60-260 мг/л буюу голын бохирдол харьцангуй бага байсан. Гэвч Туул голын ус нь жил ирэх тусам байгалийнхаа аясаараа цэвэрших чадамж буурч, голын усны бохирдлын үзүүлэлт ихсэж, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс олон дахин давж, бохирдлын орон зай ихсэж байгаа нь голын урсгалын доод хэсэгт уг голоос ундаалж буй хүн болоод мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрснийг өмнөх судлаачдын судалгааны дүн харуулж байна [16]. Ялангуяа Улаанбаатар хотын баруун урд хэсэг буюу Биокомбинат орчмоос эхлэн голын усны чанар, найрлага огцом өөрчлөгдөж байгаа нь Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн (ТЦБ) бохир ус бүрэн гүйцэд цэвэршиж чадалгүй Туул голд хаягдаж байгаатай холбоотой [50].

Тиймээс бид Туул голын урсгалын дагуух Тэрэлжээс Төв аймгийн Лүн сум хүртэлх 10 цэгт судалгаа хийж, усны чанар, бохирдлын түвшин тогтоож дүгнэлт өгөх зорилгоор энэхүү ажлыг хийж гүйцэтгэв.

Судалгааны объект: Суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Туул голын урсгалын дагуу Тэрэлжийн бүс (Т1-Тэрэлжийн гүүр), Улаанбаатар хот орчмын бүс (Т2-Баянзүрхийн гүүр, Т3-Маршалын гүүр, Т4-Яармагийн гүүр, Т5-Сонсголонгийн гүүр), Биокомбинатын бүс (Т6-Биокомбинат, Т7-Шувуун фабрик, Т8-Төв аймаг Алтанбулаг сум), Лүнгийн бүс (Т9-Төв аймаг Өндөрширээт сум, Т10-Лүнгийн гүүр) гэсэн 4 бүсийн

10 цэгээс намар, хавар, зуны улиралд сорьц цуглуулан судалгааг хийж гүйцэтгэсэн болно (Зураг 10).



Зураг 10. Туул голоос сорьц авсан цэгийн байршил

Физик-химийн шинж чанар: Цахилгаан дамжуулах чанар (ЦДЧ), нийт ууссан давс (TDS) болон рН нь тухайн усны шинж чанарыг илтгэдэг чухал үзүүлэлтүүд юм. Судалгаанд хамрагдсан голын усны сорьц цуглуулсан байршил болон физик-химийн үзүүлэлтүүдийг хүснэгт 53-д үзүүлэв. Хүснэгтээс харахад Туул голын усны рН 6.46-8.64 буюу саармагаас бага шүлтлэг орчинтой байсан бөгөөд Лүнгийн бүсийн (Т10) хаврын улирлын сорьц рН-ийн утгаараа “Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1998 стандарт шаардлагыг хангахгүй байна. Цахилгаан дамжуулах чанар болон нийт ууссан давс нь тухайн усны эрдэсжилттэй шууд хамааралтай байдаг. Судалгаа хийсэн голын усны цахилгаан дамжуулах чанар Тэрэлж, Улаанбаатар хот орчимд 3.7-10.7 mS/m байхад Биокомбинат, Лүн орчмын бүсэд 11.5-98 mS/m агуулагдаж байгааг тодорхойлов. Үүнээс үзэхэд төв цэвэрлэх байгууламжийн бохир нийлсэн Т6 цэгээс эхлэн голын усны эрдэсжилт болон цахилгаан дамжуулах чадвар нэмэгдэж байна.

Хүснэгт 53. Сорьц цуглуулсан цэгүүдийн байршил болон физик-химийн үзүүлэлт

Бүс	Сорьц авсан цэг	Өргөрөг (N)	Уртраг (E)	Улирал	рН	EC, mS/m	TDS, ppm
Тэрэлжийн бүс	Т1	47°48'41.55'	107°21'55.67"	намар	7.47	6	30
				хавар	7.37	3.7	18
				зун	6.86	4.1	20
Улаанбаатар хот орчмын бүс	Т2	47°53'23.27'	107°03'20.91"	намар	7.33	7	35
				хавар	7.3	3.9	20
				зун	6.84	4.7	23
	Т3	47°53'23.27'	106°56'23.24"	намар	7.46	7.2	36
				хавар	7.17	4.3	21
				зун	6.79	4.9	24
Т4	47°53'07.06"	106°51'40.16"	намар	7.49	7.5	37	

	Т5	47°52'23.48"	106°47'05.68"	хавар	7.12	4.5	22
				зун	6.82	5.3	26
				намар	7.57	10.7	53
				хавар	7.04	4.8	24
				зун	6.87	5.9	29
Биокомбинат ын бүс	Т6	47°51'57.23'	106°41'41.16"	намар	6.95	86.8	431
				хавар	7.35	98	488
				зун	6.46	24.3	121
	Т7	47°45'31.74'	106°33'47.28"	намар	7.01	30.4	151
				хавар	7.43	11.5	57
				зун	6.52	11.9	57
	Т8	47°42'54.44'	106°23'31.87"	намар	7.28	28.2	143
				хавар	7.31	15.9	79
				зун	6.61	14.4	71
Лүнгийн бүс	Т9	47°33'37.16'	104°59'36.45"	намар	7.55	23.3	115
				хавар	7.63	18.2	91
				зун	7.03	13.3	67
	Т10	47°51'46.23'	105°11'51.84"	намар	7.4	24.6	123
				хавар	8.64	17.6	88
зун	7.21	14.6	73				
MNS 4586:1998					6.5-8.5	-	-

Химийн найрлага: Судалгаанд хамрагдсан Туул голын усны химийн шинжилгээний дүнг хүснэгт 54-т үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад Туул голын усны нийт хатуулаг 0.4-4.2 мг-экв/л, кальци (Ca^{2+}) 6-58.1 мг/л, натри+кали ($Na^{++}K^{+}$) 5.6-159.7 мг/л, магни (Mg^{2+}) 1.2-15.8 мг/л, гидрокарбонат (HCO_3^-) 36.6-396.5 мг/л, хлор (Cl^-) 8.9-115.2 мг/л, сульфат (SO_4^{2-}) 2.5-93.8 мг/л, нийт эрдэжилт 71.7-851.6 мг/л хооронд агуулагдаж байна. Дээрх дүнгээс харахад Биокомбинатын бүс буюу (Т6, Т7, Т8), Лүнгийн бүс (Т9, Т10) цэг нь Тэрэлжийн гүүрний (Т1) цэгээс хатуулаг 2.6-6.9, кальци 2.75-6, магни 1.6-3.9, гидрокарбонат 2.3-7.8, хлор 1.65-7.4, сульфат 3.9-7.9, нийт эрдэжилт 2.4-7.8 дахин их тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 54. Туул голын усны голлох ионуудын агуулга, мг/л

Бүс	Сорьц авсан цэг	Улирал	Нийт хатуулаг, мг-экв/л	$Na^{++}K^{+}$	Ca^{2+}	Mg^{2+}	HCO_3^-	Cl^-	SO_4^{2-}	Нийт эрдэжилт
Тэрэлжийн бүс	Т1	намар	0.7	7.3	10.0	2.4	42.7	9.2	2.5	74.9
		хавар	0.4	15.3	6.0	1.2	36.6	11.8	8.2	80.8
		зун	0.9	6.2	8.0	6.1	36.6	13.3	9.1	79.9
Улаанбаатар хот орчмын бүс	Т2	намар	0.7	15.3	10.0	2.4	48.8	9.2	14.0	100.7
		хавар	0.4	18.1	6.0	1.2	36.6	11.8	13.2	87.9
		зун	0.8	5.7	8.0	4.9	36.6	13.3	3.3	72.5
	Т3	намар	0.7	15.6	8.0	3.6	48.8	9.2	14.8	101.2
		хавар	0.6	16.2	8.0	2.4	36.6	11.8	18.9	95.1
		зун	0.8	15.9	8.0	4.9	36.6	13.3	24.7	104.1
	Т4	намар	1	16.4	12.0	4.9	48.8	12.3	26.3	121.7
		хавар	0.5	10.4	8.0	1.2	36.6	8.9	5.8	71.7
		зун	0.8	6.7	8.0	4.9	36.6	10.0	9.9	76.8
	Т5	намар	1.1	8.7	16.0	3.6	54.9	12.3	7.4	108.2
		хавар	0.5	18.3	8.0	1.2	36.6	11.8	18.1	95.3
		зун	0.9	15.1	8.0	6.1	42.7	10.0	27.2	110.4
Биокомбинатын бүс	Т6	намар	4.1	117.4	58.1	14.6	390.4	104.5	36.2	739.1
		хавар	4.2	159.7	58.1	15.8	396.5	115.2	93.8	851.6

	T7	зун	2	23.8	28.1	7.3	122.0	33.3	26.3	250.0
		намар	1.9	24.0	28.1	6.1	140.3	24.6	28.0	262.8
		хавар	1	29.9	12.0	4.9	61.0	14.8	47.7	174.6
	T8	зун	1	14.8	14.0	3.6	61.0	13.3	14.8	125.1
		намар	2.6	23.6	38.1	8.5	152.5	24.6	15.6	273.6
		хавар	1.2	17.0	16.0	4.9	73.2	17.7	18.1	152.2
Лүнгийн бүс	T9	зун	1.4	9.8	18.0	6.1	67.1	16.7	12.3	135.4
		намар	1.7	28.3	26.1	4.9	109.8	21.5	30.5	228.9
		хавар	1.4	36.6	22.0	3.6	79.3	17.7	51.0	219.6
	T10	зун	1.4	33.6	18.0	4.9	67.1	20.0	53.5	202.1
		намар	1.9	14.6	30.1	4.9	109.8	21.5	10.7	202.1
		хавар	1.6	18.0	26.1	3.6	61.0	17.7	19.8	165.1
		зун	1.7	5.6	20.0	8.5	67.1	16.7	14.0	137.8

Туул голын ус эхэн хэсэгтээ буюу Тэрэлжийн бүсэд нэн цэнгэг устай байгаа бол Улаанбаатар хот орчмын бүсэд голын усны эрдэсжилт ойролцоогоор 1.2 дахин нэмэгдсэн байгаа нь суурьшлын бүстэй ойр хүний үйл ажиллагаанаас хамаарч бохирдож эхэлж байгааг харуулж байна. Харин Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир ус нийлсэн (Биокомбинатын Т6) цэгт голын усны эрдэсжилт болон бусад анион катион илүү их нэмэгдэн бохирдож байгаа нь ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэглээнээс гарсан хаягдал усыг цэвэрлэн “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015-н шаардлагыг хангасан усыг хүрээлэн буй орчинд нийлүүлж чадахгүй байгаа бөгөөд хүний хүчин зүйлээс голын усны бохирдол үүссэнийг харуулж байна [49]. Лүнгийн бүсэд (Т9, Т10) голын ус байгалийн усны өөрөө цэвэрших явцын дүнд нийт эрдэсжилт болон хатуулаг буурах зүй тогтол ажиглагдаж байгаа хэдий ч Тэрэлж орчмын Т1 цэгтэй харьцуулахад гүйцэд цэвэршиж чадахгүй байгааг тодорхойлов.




График 39. Туул голын химийн найрлагын гурвалжингийн график

Судалгаанд хамрагдсан Туул голын усны химийн найрлагыг (намар, хавар, зун) улирлаас хамааруулан гурвалжингийн диаграммаар илэрхийлэн график 39-т үзүүлэв. Тус графикийн катионы гурвалжингаас харахад Туул голын усанд (Т1-Т10) цэгүүдэд намрын улиралд Ca^{2+} , хавар Na^{+} , зуны улиралд Ca^{2+} , Mg^{2+} ион тус тус давамгайлж

байна. Харин анионы гурвалжингаас харахад зун, намрын улиралд HCO_3^- , хавар HCO_3^- , SO_4^{2-} ион зонхилж байна. Үүнээс үзэхэд Туул голын ус намар HCO_3^- - Ca^{2+} , хаврын улиралд HCO_3^- , SO_4^{2-} - Na^+ , зуны улиралд HCO_3^- - Ca^{2+} , Mg^{2+} төрлийн холимог найрлагатай усны ангилалд хамаарагдаж байна. Энэ нь шар усны үер, хур борооны улирал зэргээс хамаарч голын усны химийн найрлага өөрчлөгдөж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Туул голын (Т1-Т10 цэгийн) усны шим бохирдлын үзүүлэлт болох аммонийн азот, нитритийн азот, исэлдэх чанар, эрдэс фосфорын агуулгыг “Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1998” стандарттай харьцуулан график 40-д үзүүлэв.




График 40. Туул голын шим бохирдлын үзүүлэлтүүд

Шим бохирдлын үзүүлэлтүүдийг стандарттай харьцуулсан график 2-оос харахад судалгаанд хамрагдсан 10 цэгийн исэлдэх чанар MNS 4586:1998 стандартаас хэтэрсэн байгаа нь Туул голын усны хүчилтөрөгчийн горим алдагдсан байгааг илтгэж байна. Тэрэлж, Улаанбаатар хотын бүсэд (Т1-Т5 цэгт) аммонийн азот ($\text{NH}_4\text{-N}$) 0.12-0.31 мг/л, нитритийн азот ($\text{NO}_2\text{-N}$) 0-0.002 мг/л, эрдэс фосфор ($\text{PO}_4\text{-P}$) илрэхгүй байгаа нь стандарт хэмжээнээс хэтрэхгүй байгаа бөгөөд дээрх 2 бүсийн голын ус шим бодисын бохирдлоор бохирдоогүй байгааг харуулж байна. Харин Биокомбинатын Т6 цэгт аммонийн азот 7.11 мг/л буюу стандартаас 14 дахин, нитритийн азот 0.12 мг/л буюу стандартаас 5.8 дахин, эрдэс фосфор 0.15 мг/л буюу стандартаас 1.5 дахин их байгаа нь Төв цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал бохир ус бүрэн гүйцэд цэвэрлэгдэлгүй Туул голд нийлж байгааг илтгэж байна. Харин Т7-Т10 цэгийн аммонийн азот 0.12-2.93 мг/л, нитритийн азот 0.02-0.136 мг/л, эрдэс фосфор 0.02-0.03 мг/л агуулагдаж байгаа нь Т6 цэгээс харьцангуй буурсан байгаа хэдий ч аммони болон нитритийн азот MNS 4586:1998 стандартын шаардлага хангахгүй байна. Шим бодисын бохирдлын үзүүлэлтүүдээс аммонийн азот ($\text{NH}_4\text{-N}$) давамгайлж байгаа нь хүний хүчин

зүйлээс шууд хамааралтай байна. Учир нь $\text{NH}_4\text{-N}$ нь ахуйн хог хаягдлын гаралтай усанд их хэмжээгээр үүсдэгтэй холбоотой юм [51, 52].

Усны чанарын индекс (УЧИ): Гадаргын усны шим бохирдлын үзүүлэлтүүд нь усны чанарт үнэлгээ өгч, бохирдлын зэргийг тогтоох шалгуур үзүүлэлт болдог байна [59]. Туул голын усны чанарын индексийг усны орчин, шим бохирдлын үзүүлэлтүүд (ИЧ, $\text{NH}_4\text{-N}$, $\text{NO}_2\text{-N}$, $\text{PO}_4\text{-P}$)-ийн агуулгаар тооцож намар, хавар, зуны улирал тус бүрээр гаргаж үр дүнг хүснэгт 55, график 40-т үзүүлэв.

Хүснэгт 55. Туул голын усны чанарын индекс

Улирал	T1	T2	T3	T4	T5	T6	T7	T8	T9	T10
Намар	0.18	0.19	0.2	0.2	0.22	4.55	3.36	2.37	2.73	1.59
Хавар	0.83	0.72	0.5	0.7	0.83	4.45	1.36	1.69	0.69	0.99
Зун	0.22	0.26	0.3	0.2	0.34	2.77	1.74	2.47	0.68	0.73
Бохирдлын зэрэг	I-II	I-II	I-II	I-II	I-II	IV-V	III-IV	III-IV	II-III	II-III

Хүснэгт 55, график 41-с харахад T1-T5 цэгт намрын улиралд усны чанарын индекс (0.18-0.26) буюу Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм (ГУЦЗАН)-ын “Маш цэвэр” (I) ангилалд байсан бол хаврын улиралд (0.51-0.83) буюу усны чанар бага зэрэг буурч “Цэвэр” (II) ангилалд, зуны улиралд (0.2-0.39) буюу “Маш цэвэр (I)-ээс цэвэр (II)” ангилалд хамаарагдаж байна. ТЦБ-н бохир ус нийлсэн Т6 цэгт намар, хаврын улиралд усны чанарын индекс (4.45-4.55) буюу ГУЦЗАН-ын “Их бохирдолтой” (V) ангилалд, зуны улиралд (2.77) буюу “Бохирдолтой” (IV) ангилалд хамаарагдаж байна. Харин T7-T10 цэгт усны чанарын индекс намрын улиралд (1.59-3.36) буюу “Бага бохирдолтой (III)-оос Бохирдолтой (IV)”, хавар болон зуны улиралд (0.99-2.47) буюу “Бага бохирдолтой” (III) ангилалд тус тус хамаарагдаж байна.




График 41. Туул голын усны чанарын индексийн тархалт

Үүнээс үзэхэд Туул голын ус эхэн хэсэгтээ буюу Тэрэлж, Улаанбаатар хот орчмын бүсэд (Т1-Т5 цэг) “Маш цэврээс цэвэр” (I-II) усны ангилалд хамаарагдаж байгаа бөгөөд ТЦБ-н бохир ус нийлсэн Т6 цэг “Бохирдолтойгоос их бохирдолтой” буюу (IV-V), Т7-Т10 цэгт усны чанар “Бохирдолтойгоос бага бохирдолтой” (III-IV) ангилалд хамаарагдаж байна. Түүнчлэн Лүнгийн Т10 цэгийг Тэрэлжийн бүсийн Т1 цэгтэй харьцуулахад голын ус өөрөө цэвэрших процесс гүйцэд явагдаж чадахгүй байгааг харуулж байна. Мөн Туул голын усны чанарын судалгааны дүнг Ч.Жавзан, Т.Энхжаргал, Д.Одонцэцэг нарын өмнөх судлаачдын дүнтэй харьцуулахад ижил зүй тогтолтой буюу Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал ус нийлсэн хэсгээс эхлэн бохирдолтойгоос их бохирдолтой усны ангилалд хамаарагдаж байгаа бөгөөд Лүнгийн гүүр орчмоос эхлэн голын ус байгалийн усны өөрөө цэвэрших явцын дүнд бохирдлын түвшин буурч байгааг тайлангийн IV бүлэгт тусгаж өгсөн болно.

Бичил элементүүдийн агуулга: Туул голын урсгалын дагуух сонгогдсон 6 цэгийн усанд микроэлементийн агууламжийг тодорхойлж “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998 стандарт, ГУЦЗАН-ын нормтой харьцуулж хүснэгт 56-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад Т1, Т3, Т5 цэгт Co (<0.06), Ni (<0.3), Mo (0.3-0.5 мкг/л), As (0.54-0.85 мкг/л) агуулагдаж байхад ТЦБ-ын бохир ус нийлсэн Т6, Т8, Т10 цэгүүдэд дээрх элементүүд Co (0.06-0.19 мкг/л), Ni (<0.3-0.7 мкг/л), Mo (0.8-1.8 мкг/л), As (0.99-3.3 мкг/л) бага хэмжээгээр нэмэгдсэн байгаа хэдий ч MNS 4586:1998 стандартын шаардлага хангаж байна. Мөн голын усны микроэлементийн агуулгыг ГУЦЗАН-тай харьцуулахад “Бага бохирдолтой” буюу (III) зэргийн усны ангилалд хамаарч байна.

Хүснэгт 56. Туул голын микроэлементийн агуулга, мкг/л

Бүс	Сорьц авсан цэг	Улирал	Cr	Cu	Mn	Zn	Co	Ni	Mo	As	Cd	Hg	Pb
Тэрэлжийн бүс	Т1	намар	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.4	0.59	<0.01	<0.05	<0.5
		хавар	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.4	0.62	0.02	<0.05	<0.5
		зун	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.3	0.59	0.02	<0.05	<0.5
Улаанбаатар хотын бүс	Т3	намар	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.5	0.72	<0.01	<0.05	<0.5
		хавар	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.5	0.67	0.02	<0.5	<0.5
		зун	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.3	0.57	0.02	<0.05	<0.5
	Т5	намар	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.5	0.85	<0.01	<0.05	<0.5
		хавар	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.5	0.66	<0.01	<0.05	<0.5
		зун	<10	<5	<5	<5	<0.06	<0.3	0.3	0.54	<0.01	<0.05	<0.5
Биокомбинатын бүс	Т6	намар	<10	<5	<5	<5	0.15	0.7	1.8	1.98	0.01	<0.05	<0.5
		хавар	<10	<5	<5	<5	0.15	0.7	1.3	1.73	0.01	<0.05	<0.5
		зун	<10	<5	<5	<5	0.19	0.7	0.8	0.99	0.01	<0.05	<0.5
	Т8	намар	<10	<5	<5	<5	0.06	<0.3	1.1	2.49	<0.01	<0.5	<0.5
		хавар	<10	<5	<5	<5	0.1	<0.3	1.1	1.93	<0.01	<0.05	<0.5
		зун	<10	<5	<5	<5	0.09	0.4	0.9	1.82	<0.01	<0.05	<0.5
Лүнгийн бүс	Т10	намар	<10	<5	<5	<5	0.1	0.5	1.6	3.29	<0.01	<0.5	<0.5
		хавар	<10	<5	<5	<5	0.1	0.5	1.7	2.85	<0.01	<0.5	<0.5
		зун	<10	<5	<5	<5	0.11	0.5	1.7	3.3	<0.01	<0.05	<0.5
MNS 4586:1998			50	10	100	10	10	10	250	10	5	0.1	10
ГУЦЗАН-ын "Бага бохирдолтой" (III)			200	50	100	1000	20	50	100	100			

Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан Туул голын ус нь саармагаас бага шүлтлэг орчинтой, улирлаас хамаарч (шар усны үер, хур борооны улиралд) химийн найрлага өөрчлөгдөж HCO_3^- - Ca^{2+} , HCO_3^- , SO_4^{2-} - Na^+ , HCO_3^- - Ca^{2+} , Mg^{2+} -ийн төрлийн холимог найрлагатай усны ангилалд хамаарагдаж байна. Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир ус нийлсэн Т6 цэгт “Бохирдолтойгоос их бохирдолтой” буюу IV-V усны ангилалд хамаарагдаж байгаа нь ТЦБ нь ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэглээнээс гарсан хаягдал усыг цэвэрлэн “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015-н шаардлагыг хангасан [53] усыг хүрээлэн буй орчинд нийлүүлж чадахгүй байгаа бөгөөд хүний хүчин зүйлээс голын усны бохирдол үүсэж байгааг илэрхийлж байна. Лүнгийн Т9, Т10 цэгийн голын ус байгалийн усны өөрөө цэвэрших явцын дүнд бохирдлын түвшин буурч байгаа хэдий ч Тэрэлжийн Т1 цэгтэй харьцуулахад гүйцэд цэвэрших процесс явагдаж чадахгүй байгааг тодорхойлов. Туул голын усны микроэлементийн агуулгыг ГУЦЗАН-тай харьцуулахад “Бага бохирдолтой” буюу III зэргийн усны ангилалд хамаарч байгааг тодорхойлов.

4.2. Усны чанарын үзүүлэлтүүдийн судалгаанд хиймэл оюуны ухаан (ANN)-д суурилсан загварчлалын аргыг ашигласан үр дүн

Усны эх үүсвэрийг гадаргын ус (гол, нуур, усан сан гэх мэт) болон гүний ус (булаг шанд) гэж ангилдаг. Байгалийн үйл явц (хур тунадас, элэгдэл, өгөршил гэх мэт), антропоген үйл ажиллагаа (хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэр, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа), усны эх үүсвэрийн ашиглалт нэмэгдэж байгаа нь гадаргын усны чанарт нөлөөлдөг [54]. Тиймээс гадаргын усны чанар нь устай холбоотой байгаль орчин, эрүүл мэндэд эрсдэл учруулдаг тул тулгамдсан асуудлын нэг болоод байна [55]. Иймээс усны чанарыг найдвартай, тогтмол хянах арга барилтай байх нь амин чухал юм [56]. Гэсэн хэдий ч дээж цуглуулах, лабораторийн шинжилгээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх нь химийн бодис, тоног төхөөрөмж, хүн хүчний хувьд цаг хугацаа их шаарддаг, зардал их шаарддаг [57]. Ийм учраас судлаачид найдвартай менежментийн бодлого, урьдчилан сэрэмжлүүлгийн дэвшилтэт системийг хөгжүүлэхийн тулд тооцоолол, таамаглал, эрсдэлийн үнэлгээ, бохирдуулагчийн ангиллын арга барилд анхаарлаа хандуулж эхэлсэн байна [58].

1925 оноос олон улсын хэмжээнд гадаргын усны чанар, тэдгээрийн өөрчлөлтийг судлан шинжлэх, таамаглахад усны чанарын загварчлалын аргыг ашиглаж эхэлсэн бөгөөд SWAT, WASP, QUALs, MIKE 11 зэрэг усны чанарын загварчлалын аргуудыг зориулалт, хөгжүүлэлт, өгөгдөл, үндсэн зарчим, давуу болон сул тал, тодорхой нөхцөл байдалд нь үндэслэн усны чанарын судалгаанд түгээмэл хэрэглэсээр ирсэн байна [59]. Гэсэн хэдий ч усны чанарын өгөгдөл нь шугаман бус, цэгийн бус эх үүсвэрийн шинж чанар, байгалийн урьдчилан таамаглах боломжгүй өөрчлөлт, харилцан хамаарал, хүний оролцоо зэргээс шалтгаалж тодорхой бус шинж чанартай тул загварчлахад хүндрэлтэй байдаг бөгөөд үүнд асар их цаг хугацаа, хөрөнгө мөнгө болон ажиллах хүмүүс шаардлагатай байдаг [60-61]. Тиймээс өгөгдөлд тулгуурласан болон хиймэл оюун ухаан (artificial intelligence-AI)-д суурилсан загварчлалын аргууд, тэдгээрийн дэвшилтэт хэрэгслүүдийг сүүлийн үед усны чанарын загварчлал гэх мэт судалгаанд өргөн хэрэглэж байна [62-67]. Өгөгдөлд тулгуурласан болон хиймэл оюун ухаанд суурилсан загварчлалын аргуудыг ашиглахын давуу тал нь өгөгдлөөс бие даан суралцах, алдааг багасгах замаар нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх чадвараас үүдэлтэй байдаг.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн ам хурдацтай өсөж, одоогийн байдлаар улсын хүн амын талаас илүү хувийг эзэлж байгаа тул Туул голын экологийн аюулгүй байдал нь улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой [8, 68]. Туул голын талаар судлаачид усны чанарын үндэсний стандарт болон усны чанарын индекс (WQI) [6, 69] ашиглан усны чанарыг үнэлэх, хүнд металлын агууламж болон тархалтыг тодорхойлох, усны эх үүсвэрт усны хагалбарын үйл явцын нөлөөллийн шинжилгээнд SWAT загварыг ашиглах зэрэг судалгаанууд хийсэн байна. Тиймээс энэхүү судалгаанд Туул голын усны физик-химийн чанарын үзүүлэлтүүдийг хиймэл оюун ухааны (ANN) загварчлалын аргыг таамаглах боломжийг судлах зорилго тавин Туул голын одоогийн усны чанарыг үнэлэх, ANN загварын оролт, гаралтын хувьсагчдыг сонгохын тулд Туул голын физик-химийн үзүүлэлт хоорондын хамаарлыг

тодорхойлох, гүйцэтгэлийг үнэлэх замаар ANN загварын оновчтой архитектурыг тодорхойлох судалгааг хийсэн.

Оролт болон гаралтын хувьсагчдыг сонгох: ANN загварчлалд ашиглагдах оролт, гаралтын хувьсагчдыг сонгохын тулд хувьсагчдын хоорондын хамаарлыг тодорхойлох корреляцийн шинжилгээг ашигласан [70]. Корреляцийн коэффициентын утга -1 эсвэл 1-тэй ойролцоо буюу ойр байвал хоёр параметрийн хооронд эерэг хамааралтай, 0-тэй ойр байвал тэдгээрийн хооронд шугаман хамаарал байхгүй гэсэн үг [71]. Иймээс Cohen-ы хамаарлын нөлөөллийн хэмжээг хамаарлын үр дүнг тоон байдлаар харьцуулахдаа ашигласан (Хүснэгт 57). Дараах томъёог ашиглан нь корреляцийн коэффициентыг тооцоолсон болно.

$$r = \frac{\sum(x_i - \bar{x}) - (y_i - \bar{y})}{(x_i - \bar{x})^2 - (y_i - \bar{y})^2} \quad (2)$$


x_i, y_i – хувьсагчдын утга

\bar{x}, \bar{y} – x, y хувьсагчдын дундаж утга

Хүснэгт 57. Cohen-ы хамаарлын нөлөөлөл

Корреляцийн коэффициент (r)		Хамаарлын хүч
Эерэг	Сөрөг	
	0.0	Хамааралгүй
0.01 – 0.30	-0.1 - -0.3	Сул
0.31 – 0.50	-0.3 – -0.5	Дунд
0.51 – 0.70	-0.5 – -0.7	Хүчтэй
0.71 – 1.00	-0.7 - -1.0	Их хүчтэй

Хиймэл оюун ухаан (Artificial Neural Network-ANN): ANN нь хиймэл оюун ухаанд суурилсан машин сургалтын техник бөгөөд оролт, гаралт, далд, янз бүрийн тооны нейронуудаас бүрддэг бол нейрон бүр нь жин (w), хазайлт (b) болон дамжуулах функц (f) зэрэг гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг [72, 73]. Ерөнхий зураглалыг 11-р зурагт үзүүлэв. Далд давхарга дахь нейронуудын тоо нь чухал процедур юм. Хэрэв нейронуудын тоо бага бол сүлжээний өгөгдлийг зөв мэдэрч чадахгүй, харин хэт их байвал сургалтын үргэлжлэх хугацаа удааширч сүлжээний өгөгдөлд хэтрэх магадлалтай [74]. ANN загварчлалын гүйцэтгэл нь шугаман бус харилцааг тогтооход ашигладаг сургалтын алгоритмаас хамаардаг [75]. Иймд энэхүү судалгаанд MATLAB R2018b программд дараах алгоритмуудыг ашиглан ANN загварыг боловсруулсан болно. Үүнд: Levenbergh-Marquardt-Энэ нь шугаман бус оновчлолын техник бөгөөд бусад буцах тархалтын техникээс илүү хурдан бөгөөд найдвартай, Bayesian-regularization-Энэ нь сүлжээний архитектураас гадна сайн тохирох байдлыг харгалзан үзэх замаар хэт тохирох асуудлыг багасгадаг [76, 77]. Далд давхарга дахь нейроны тоог ерөнхий дүрмийн аргыг ашиглан сонгосон: (а) оролт ба гаралтын давхаргын нейроны тоо хооронд байх, (б) ойролцоо (оролт+гаралт)*2/3 , эсвэл (в) оролтын давхарга дахь нейроны тооноос хэзээ ч хоёр дахин их байх болон туршилт, алдааны процесс [D] зэргийг сонгосон.



Зураг 11. Оролтын, далд, гаралтын давхарга гэсэн гурван давхарга бүхий ANN загварын архитектур (x-оролт, y-гаралт, хэвийлт нь сургалтын үйл явц ба w – жингээр тодорхойлогддог)

Гүйцэтгэлийн үнэлгээ: Сургалт, баталгаажуулалт, туршилтын багцын дундаж квадрат алдааны (MSE) хамгийн бага утгад үндэслэн ANN загварын оновчлолын гүйцэтгэлийг тодорхойлсон [78]. MSE нь тохирох байдлыг тодорхойлох сайн статистик арга бөгөөд ажиглагдсан болон таамагласан утгын зөрүүний квадратуудын дундаж нийлбэрээр тодорхойлогддог. Тооцооллыг дараах тэгшитгэлээр илэрхийлнэ.

$$MSE = \frac{1}{n} \sum_{i=1}^n (Y_i - \bar{Y}_i)^2 \quad (3)$$

Үр дүн, хэлэлцүүлэг-ANN загварчлалын оролт ба гаралтын хувьсагчдыг сонгох: Физик-химийн үзүүлэлтүүд хоорондын хамаарлын шинжилгээг хавсралт 7-д үзүүлсэн хамаарлыг Cohen [79]-ын хэрэглэсэн нөлөөллийн хэмжээтэй уялдуулан үр дүнгээс хассан болно. Корреляцийн шинжилгээний үр дүнд хлорид (Cl⁻) ба биологийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ₅) нь ууссан хатуу бодисын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гадаргын усны бохирдлын боломжит үзүүлэлт болох тул гаралтын хувьсагчаар сонгогдсон [80-83]. Cl⁻ нь ЕС (r=0.99), TDS (r=0.99), TH (r=0.94), XXX (r=0.87), БХХ₅ (r=0.86), Na⁺+K⁺ (r=0.91), Ca²⁺ (r=0.93), Mg²⁺ (r=0.96), NH₄⁺ (r=0.97), HCO₃⁻ (r=0.996), эрдэсжилт (r=0.97)-тэй маш хүчтэй эерэг хамаарлыг харуулж байна. Харин PO₄³⁻ (r=0.51)-тай хүчтэй эерэг хамаарал, SO₄²⁻ (r=0.42) ба NO₂⁻ (r=0.49)-тай дунд зэргийн эерэг хамааралтай байна. Ийнхүү эдгээр 11 хувьсагч (ЕС, TDS, TH, XXX, БХХ₅, Na⁺+K⁺, Ca²⁺, Mg²⁺, NH₄⁺, HCO₃⁻ ба эрдэсжилт) нь Cl-тэй маш хүчтэй эерэг хамаарлыг харуулсан тул оролт болгон сонгосон.

Харин BOD₅ нь ЕС (r=0.84), TDS (r=0.81), TH (r=0.70), XXX (r=0.96), БХХ₅ (r=0.86), Na⁺+K⁺ (r=0.77), Mg²⁺ (r=0.75), NH₄⁺ (r=0.87), HCO₃⁻ (r=0.83), Cl⁻ (r=0.86), PO₄³⁻ (r=0.70), эрдэсжилт (r=0.79)-тэй маш хүчтэй эерэг хамаарлыг харуулж байна. Харин Ca²⁺ (r=0.93)-тай дунд зэргийн эерэг хамаарлыг харуулж байна. Ийнхүү 12 хувьсагч (ЕС, TDS, TH, XXX, Na⁺+K⁺, Ca²⁺, Mg²⁺, NH₄⁺, Cl⁻, HCO₃⁻, PO₄³⁻ ба эрдэсжилт) нь БХХ₅-тай маш хүчтэй эерэг хамаарлыг харуулсан тул оролт болгон сонгосон.

ANN загварчлал: ANN загварын архитектур дахь давхаргууд болон нейронуудын тоог тодорхойлохын өмнө бүх өгөгдлийн багцыг сургалт (70%), баталгаажуулалт (15%) болон туршилтын (15%) багц болгон хуваасан. Оновчлолын хувьд Levenbergh-Marquardt (LM) болон Bayesian Regularization (BR) зэрэг хамгийн алдартай сургалтын алгоритмуудыг ашигласан [84-86]. Далд давхарга дахь хэд хэдэн нейроныг эрхий хурууны дүрмийн дагуу тодорхойлж, туршилт-алдааны процессыг дагаж өөр өөр тооны далд нейроныг LM болон BR сургалтын алгоритмаар тус тус туршсан. Загвар тус бүрт ашигласан сургалт, баталгаажуулалт, туршилтын өгөгдлийн багцад тооцоолсон дундаж квадрат алдааг (MSE) Хүснэгт 59-д үзүүлэв.

Хүснэгт 59. LM болон BR алгоритмуудыг ашиглан далд давхарга дахь өөр өөр тооны нейрон бүхий сургалт, баталгаажуулалт, туршилтын багц бүрийн MSE утгууд

Багц	Нейроны тоо	Cl ⁻		BOD ₅	
		LM	BR	LM	BR
Сургалт	7	-	-	42.282	26.848
	8	8.068	2.758	17.669	45.824
	9	6.384	0.157	16.123	11.276
	10	6.956	0.103	15.754	34.245
	11	5.452	0.117	176.671	51.455
	12	30.993	0.043	229.382	19.360
	13	-	-	32.707	37.541
Баталгаажуулалт	7	-	-	942.682	-
	8	4.181	-	369.667	-
	9	1.914	-	895.756	-
	10	14.960	-	294.255	-
	11	6.239	-	512.151	-
	12	85.343	-	66.496	-
	13	-	-	430.993	-
Туршилт	7	-	-	415.598	251.801
	8	170.084	1.10E+03	75.286	874.172
	9	184.501	20.337	293.349	467.508
	10	31.401	100.766	757.584	514.575
	11	95.300	691.66	403.486	780.535
	12	109.592	45.198	1321.770	160.898
	13	-	-	526.001	1568.178

Хлорид (Cl⁻)-ын загварчлалын хувьд 11 оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, арван нейрон бүхий далд давхарга, нэг хувьсагчтай (CLLM 11-10-1) гаралтын давхаргаас бүрдэх LM алгоритмаар оновчтой болгосон ANN загварыг гүйцэтгэсэн. Харин ANN загвар нь 11 оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, 9 нейрон бүхий далд давхарга, нейрон бүхий гаралтын давхарга (CLBR 11-9-1) зэргээс бүрдэх BR алгоритмаар оновчтой болгосон. CLLM 11-10-1 ба CLBR 11-9-1 загваруудын загварчилсан Cl⁻ утгуудын эсрэг ажиглагдсан графикуудыг (график 42, 43) үзүүлэв. CLBR 11-9-1 нь хамгийн зөв Cl⁻-ын таамаглалыг загварчилсан нь харагдаж байна (MSE=3.34, R²=0.992).





График 42. Cl-ийг тооцоолоход зориулж LM-ээр бэлтгэгдсэн CLLM 11-10-1 загварын графикууд





График 43. Cl-ийг тооцоолоход зориулж BR-ээр бэлтгэгдсэн CLBR 11-9-1 загварын графикууд





График 44. BOD тооцоолоход зориулж LM-ээр бэлтгэгдсэн BODLM 11-8-1 загварын графикууд




График 45. БХХ-ийг тооцоолоход зориулж BR-ээр бэлтгэгдсэн BOD 11-12-1 загварын графикууд

БХХ-ийн хувьд, 11 оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, 8 нейрон бүхий далд давхарга, нэг хувьсагчтай (BODLM 11-8-1) гаралтын давхаргаас бүрдэх LM алгоритмаар оновчлогдсон ANN загвар нь бусад загваруудаас илүү байсан. Харин 11

оролтын хувьсагч бүхий оролтын давхарга, 12 нейрон бүхий далд давхарга, нейрон бүхий гаралтын давхарга (BODBR 11-12-1) зэргээс бүрдэх BR алгоритмаар оновчлогдсон ANN загвар нь бусад загваруудаас илүү гарсан. BODLM 11-8-1 ба BODBR 11-12-1 загваруудын загварчилсан BOD утгуудын эсрэг ажиглагдсан графикуудыг (график 44, 45) үзүүлэв. BODBR 11-12-1 нь хамгийн зөв БХХ-ийн таамаглалыг загварчилсан нь харагдаж байна ($MSE=41.603$, $R^2=0.92$).

Дүгнэлт: Туул голын Cl⁻ болон БХХ-ийг тооцоолоход зориулж хиймэл оюун ухааны (ANN) загварын хоёр өөр сургалтын алгоритмыг судалсан. Судалгаанаас харахад BR алгоритмаар бэлтгэгдсэн CLBR 11-9-1 загвар нь Cl⁻-ийн концентрацийг тооцоолох LM-ээр бэлтгэгдсэн алгоритмээс илүү гарсан байна. Харин BR алгоритмаар бэлтгэгдсэн BODBR 11-12-1 загвар нь БХХ-ийн концентрацийг тооцоолохдоо LM-ээр бэлтгэгдсэн алгоритмээс илүү гарсан. Энэхүү судалгаанаас харахад BR алгоритм нь өгөгдлийн тоо багатай тохиолдолд LM алгоритмаас илүү нарийвчлалтай болохыг харуулж байна. Цаашилбал, хиймэл оюун ухаанд суурилсан загварчлалын янз бүрийн аргуудыг харьцуулах, мөн Туул голын усны чанарыг сайжруулахад ашиглаж болно.

V. ДҮГНЭЛТ

- ❖ Эх үүсвэрийн гүний худгуудын ус нь саармаг орчинтой, зөөлнөөс хатуу, нэн цэнгэгээс цэнгэгдүү, гидрокарбонат, сульфат-кальци, сульфат-кальци, магнийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. Мөн №3-7-р худгийн ус нийт хатуулаг, кальцийн ион, № 14, 16-р худгийн ус нитратын ион, №2, 3, 12, 14-16-р худгийн усны фторын ионы агуулга ундны усны стандартад тусгагдсан доод утгад хүрэхгүй, № 5-11-р худгийн усны фторын ионы агуулга MNS зөвшөөрөгдөх дээд агууламжаас хэтэрсэн байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй байгааг тодорхойлов. Харин №2, 5, 6-р худаг цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ, 2020 онд 1 худаг, 2021 онд 4 худаг, 2022 онд 5 худгийн ус бичил амь судлалын үзүүлэлтээрээ тус тус Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байна.
- ❖ Б-станцын халдваргүйжүүлсний дараах болон хэрэглэгчдийн (эхний, эцсийн) ус нь саармаг орчинтой, зөөлнөөс хатуувтар, нэн цэнгэгээс цэнгэг усны ангилалд хамаарагдаж байна. 2020-2022 оны зарим улиралд фторын ионы агуулга стандартад тусгагдсан доод утгаас бага, зарим улиралд стандартын ЗДА-аас их байгаа нь “Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна. Энэ тухайн өдөр ажиллаж буй эх үүсвэрийн гүний худгийн усны фторын ионы агуулгаас хамаарч байгааг тодорхойлов. Мөн Б-станцын халдваргүйжүүлэлтийн дараах ус бичил амь судлалын үзүүлэлтээрээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байхад хэрэглэгчдийн ундны уснаас 2020-2022 оны (II, III, IV) улиралд нийт нянгийн тоо стандартын ЗДА-с хэтэрсэн нь MNS шаардлага хангахгүй байгааг тодорхойлов.
- ❖ Эх үүсвэрийн гүний худгуудын ус нь саармаг орчинтой, зөөлөвтөрөөс хатуувтар, гидрокарбонат-кальци, сульфат-кальци, гидрокарбонат, сульфат-кальцийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. Мөн 4-р худгийн ус кальцийн ион, бүх худгийн усны фторын ион Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тусгагдсан доод утгад хүрэхгүй байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018-н шаардлагыг хангахгүй байна. 2022 оны I, IV улиралд 3-р худаг, 2021 оны III улиралд 7-р худаг, 2022 оны IV улиралд 10, 11-р худгийн усны нийт нянгийн тоо стандарт хэмжээнээс хэтэрсэн мөн 5 худгийн ус цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ тус тус MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байгааг тогтоов.
- ❖ В-станцын халдваргүйжүүлсний дараах болон хэрэглэгчдийн ус нь саармаг орчинтой, зөөлөвтөрөөс хатуувтар, цэнгэгээс цэнгэгдүү, гидрокарбонат, сульфат-кальцийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. Мөн В станцын халдваргүйжүүлэлтийн дараах ус радоны агуулгаараа, станц болон хэрэглэгчдийн усны фторын ионы агуулга Монгол улсад мөрдөгдөж байгаа

ундны усны стандартад тусгагдсан доод утгад хүрэхгүй байгаа нь MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байна. Халдваргүйжүүлэлтийн дараах болон хэрэглэгчдийн усны ионуудын тоон утга бага зэрэг зөрүүтэй хэдий ч үндсэн бүтэц найрлага өөрчлөлтгүй байна.

- ❖ Хлор ашиглан халдваргүйжүүлэлт явуулахад усанд үүсэж болох органик нэгдлүүд буюу хлорформ, бромдихлорметан, дибромхлорметан, бромформ Б, В станцын усанд илэрч байгаа хэдий ч эдгээрийн нийлбэр буюу тригалогентметаны хэмжээ MNS 0900:2018 болон бусад улс орны мөрддөг ундны усны стандартаас 10-25 дахин бага байна.
- ❖ Харин Б, В станцын эх үүсвэрийн зарим хугацаанд толуол, стирен болон ксилолын уламжлалууд илэрсэн ч стандартад заасан хэмжээнээс маш бага байна. Үүний дотроос толуол болоод ксилолын уламжлалууд нэлээдгүй илэрсэн нь түлшний гаралтай нэгдлүүдийн өвөрмөц хувирал зүй явагдсан, тогтцын хувьд болон шилжилтийн улмаас сонирхолтой үр дүн гарч буй нь органик бүрэлдэхүүний судалгааг цаашид ангилан үргэлжлүүлэх шаардлага байна.
- ❖ Баянзүрх дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгийн ус нь саармагаас сул шүлтлэг орчинтой, зөөлнөөс хатуу, цэнгэгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Нийт 55 гүний худаг судалгаанд хамрагдсанаас 25 худгийн ус Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 болон ДЭМБ-с гаргасан улс орнуудын мөрддөг стандарт шаардлагыг хангахгүй байна. Харин 30 гүний худгийн ус ерөнхий химийн найрлага, микроэлемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөж буй MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна. Судалгаанд хамрагдсан гүний худгуудын ус нь ус, чулуулгийн харилцан үйлчлэлд орж усны бүтэц, химийн найрлага тухайн орчны геологийн тогтоц болон чулуулгаас хамаарч байгааг тодорхойллоо.
- ❖ Баянгол дүүргийн иргэдийн унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж буй гүний худгуудын ус нь саармаг орчинтой, зөөлнөөс маш хатуу, нэн цэнгэгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Мөн судалгаанд хамрагдсан гүний худгуудаас 20-р хорооны 1 худаг цахилгаан дамжуулах чанар, нийт хатуулаг, 23-р хорооны 2 худаг кальци, 20, 22, 23-р хорооны 3 худаг магни, 20, 22, 23-р хорооны 6 худаг нитрат ионы агуулгаараа, 15 худаг бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018–н шаардлагыг хангахгүй байгааг тогтоов.
- ❖ Сүхбаатар дүүргийн гүний худгуудын ус сул хүчиллэг-саармаг-сул шүлтлэг орчинтой, зөөлнөөс маш хатуу, нэн цэнгэгээс давсархаг, гидрокарбонат-кальци, магни, гидрокарбонат, сульфат-кальци, сульфат-кальци, магнийн төрлийн усны ангилалд хамаарагдаж байна. Нийт 62 гүний худаг судалгаанд хамрагдсанаас 3 худгийн ус нийт хатуулаг, 3 худаг кальцийн ион, 2 худаг магнийн ион, 7 худгийн ус нитрат ионы агуулгаараа, 17 худгийн ус бичил амь судлалын үзүүлэлтээрээ тус тус Монгол улсад мөрдөж буй ундны усны стандарт MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байгааг тогтоов.

- ❖ Судалгаанд хамрагдсан Туул голын ус нь саармагаас бага шүлтлэг орчинтой, улирлаас хамаарч (шар усны үер, хур борооны улиралд) химийн найрлага өөрчлөгдөж $\text{HCO}_3\text{--Ca}^{2+}$, HCO_3^- , $\text{SO}_4^{2-}\text{--Na}^+$, $\text{HCO}_3\text{--Ca}^{2+}$, Mg^{2+} -ийн төрлийн холимог найрлагатай усны ангилалд хамаарагдаж байна. Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир ус нийлсэн Т6 цэгт “Бохирдолтойгоос их бохирдолтой” буюу IV-V усны ангилалд хамаарагдаж байгаа нь ТЦБ нь ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэглээнээс гарсан хаягдал усыг цэвэрлэн “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015-н шаардлагыг хангасан усыг хүрээлэн буй орчинд нийлүүлж чадахгүй байгаа бөгөөд хүний хүчин зүйлээс голын усны бохирдол үүсэж байгааг илэрхийлж байна. Лүнгийн Т9, Т10 цэгийн голын ус байгалийн усны өөрөө цэвэрших явцын дүнд бохирдлын түвшин буурч байгаа хэдий ч Тэрэлжийн Т1 цэгтэй харьцуулахад гүйцэд цэвэрших процесс явагдаж чадахгүй байгааг тодорхойлов. Туул голын усны микроэлементийн агуулгыг ГУЦЗАН-тай харьцуулахад “Бага бохирдолтой” буюу III зэргийн усны ангилалд хамаарч байгааг тодорхойлов.
- ❖ Туул голын усны Cl- болон БХХ-ийг тооцоолоход зориулж хиймэл оюун ухааны (ANN) загварын хоёр өөр алгоритмыг ашигласан. Судалгаанаас харахад BR алгоритмаар бэлтгэгдсэн CLBR 11-9-1 загвар нь Cl-ийн концентрацийг тооцоолох LM-ээр бэлтгэгдсэн алгоритмээс илүү гарсан байна. Харин BR алгоритмаар бэлтгэгдсэн BODBR 11-12-1 загвар нь БХХ-ийн концентрацийг тооцоолохдоо LM-ээр бэлтгэгдсэн алгоритмээс илүү гарсан. Энэ нь BR алгоритм нь өгөгдлийн тоо багатай тохиолдолд LM алгоритмаас илүү нарийвчлалтай болохыг харуулж байна. Цаашилбал, хиймэл оюун ухаанд суурилсан загварчлалын аргуудыг ашиглан Туул голын усны чанарыг сайжруулахад ашиглаж болно.

VII. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. О.Чимэдсүрэн. 2002. Улаанбаатар хотын ундны усанд хлоржуулалтаар үүссэн зарим нэгдлүүдийг тодорхойлсон судалгаа. *Докторын диссертаци*. УБ.
2. Г.Одонтуяа, Д.Оюунцэцэг, О.Хүрэлдаваа., нар. 2020. Баянзүрх дүүргийн гүний худгуудын гидрохимийн судалгаа. Хими, химийн технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл, 8:63-69.
3. Ц.Балдандорж, Г.Цэрэнжав, Г.Удвалцэцэг. 1999. Ус түүний ашиглалтын байдлыг газарзүйн аргаар судлах туршлага. УБ хот. х.27-32
4. <http://usug.ub.gov.mn>
5. ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн. 2017. Гадаргын болон гүний ус, хөрсний чанарын үнэлгээ, тэдгээрийн бохирдлыг бууруулах судалгаа. Төслийн тайлан 2015-2017. УБ хот.
6. O.Altansukh, G.Davaa. 2011. Application of index analysis to evaluate the water quality of Tuul river in Mongolia. *Journal of Water Resource and Protection*, p 398-414. [DOI:10.4236/jwarp.2011.36050](https://doi.org/10.4236/jwarp.2011.36050)
7. Т.Энхжаргал, Д.Одонцэцэг. 2017. Туул голын усны чанар, бохирдлын түвшинг тодорхойлсон судалгааны зарим дүнгээс. Монгол орны Гидрогеологи, Инженер Геологи, Геоэкологийн асуудлууд.. ШУТИС, ГУУС, УБ хот. №25, х.108-123.
8. T.Soyol-Erdene, S.lin, E.Tuuguu., et al. 2019. Spatial and temporal variations of sediment metals in the Tuul River, Mongolia. *Environmental Science and Pollution Research*, 26(31): p. 32420-32431.
9. Enkhbayar Dandar. 2017. Water resources assessment in cold regions: th Upper Tuul river basin, Mongolia. Ph.D Thesis.
10. Х.Бадарч. 2014. Туул голын уртын урсцын хуваарилалт ба алдагдал. Магистрын судалгааны ажил. УБ хот.
11. Ч.Жавзан, Д.Гэрэлт-Од, Б.Оюун-Эрдэнэ., нар. 2019. Улаанбаатар хот орчмын гэр хорооллын суурьшлын бүсийн газар доорх усны чанарын судалгааны зарим дүнгээс. Хот байгуулалтын түүхэн үйл явц: Өнгөрсөн, одоо, ирээдүй. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.
12. Г.Одонтуяа, А.Цийрэгзэн, О.Хүрэлдаваа., нар. 2020. Сүхбаатар дүүргийн ундны усны зориулалтаар ашиглаж буй гүний худгуудын усны чанарын судалгаа. ХХТХ, “Хими-2020” ЭШБХ-ын эмхэтгэл, х.57.
13. D.Gerelt-Od, T.Enkhjargal, Z.Byambasuren., et al. 2020. Physicochemical characterization of drinking water from borehole wells in Ulaanbaatar city, Mongolia. *Proceedings of the Mongolian Academy of Sciences* 61, 02(238):23-34.
14. G.Dulamsuren, G.Odontuya, A.Tsiiregzen., et al. 20216 Microbiological and hydrochemical parameters of deep wells used for drinking water in Ulaanbaatar, Mongolia. *Proceedings of the 5th International Conference on Chemical investigation and Utilization of Natural Resource (ICCIUNR-2021)*, Atlantis Highlights in Chemistry and Pharmaceutical Sciences, Atlantis press, 2021, p89-97. ISBN:978-94-6239-436-0, ISSN:2590-3195. DOI: <https://doi.org/10.2991/ahcps.k.211004.014>

15. O.Khureldavaa, G.Odontuya, A.Tsiiregzen., et al. 2021. Assessment of groundwater quality in the Khan-Uul district, Ulaanbaatar, Mongolia. 5th International Conference on Chemical investigation and Utilization of Natural Resources (ICCIUNR 2021), Ulaanbaatar, Mongolia, p48.
16. Т.Enkhjargal, D.Gerelt-Od, Z.Byambasuren., et al. 2021. Hydrochemical and quality assessment of groundwater in the Bayanzurkh district, Mongolia. *Advances in Engineering Research*, 206:26-32.
17. Т.Булган. 2008. Усны химийн шинжилгээний аргачлал. Байгаль орчин аялал жуулчлалын яам. УБ.
18. MNS ISO 7704:1998. Монгол улсын стандарт. “Усны чанар. Бичил амь судлалын шинжилгээнд хэрэглэдэг ялтаст шүүлтүүрийн аргын үнэлгээ”. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. УБ хот. 1998.
19. MNS ISO 19250:2017. Монгол улсын стандарт. “Усны чанар. Усан дахь салмонеллын төрлийн нянг илрүүлэх”. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. УБ хот. 2017.
20. MNS ISO 22155:2012. Монгол Улсын Стандарт: “Хөрсний чанар чанар-Дэгдэмхий шинж чанартай ароматик болон галогент нүүрсустрөгчид, сонгосон эфирийн тоо хэмжээг хийн хроматографи ашиглан тодорхойлох - Уурын фазат шинжилгээний арга” Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. УБ хот. 2012
